

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ
12-Р ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2011/08/03

№03

Чойр

Хөгжлийн цогц бодлого батлах тухай

“Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 18.1.2-ын а,е заалтуудыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого” /2007-2021 он/-д тулгуурлан боловсруулагдсан “Говьсүмбэр аймгийн хөгжлийн цогц бодлого” /2010-2021 он/-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Аймгийн Хөгжлийн цогц бодлогод тусгагдсан зорилт, үйл ажиллагааг аймгийн Засаг даргын бүрэн эрхийн хугацаанд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрүүд болон аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн бодлогыг тодорхойлсон бусад баримт бичгүүдэд тусган хэрэгжүүлж байхыг аймгийн Засаг дарга /Ж.БАЯНМӨНХ/-д даалгасугай.

3. Хөгжлийн цогц бодлогын хэрэгжилтэнд хяналт тавьж, биелэлтийн явц, үр дүнг хоёр жил тутамд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдаанд танилцуулж байхыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд үүрэг болгосугай.

ДАРГА

Г.САЙНБАЯР

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн
хурлын ээлжит 12-р хуралдааны 3 дугаар
тогтоолын хавсралт



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ЦОГЦ БОДЛОГО (2010 – 2021 он)

Говьсүмбэр 2010

ГАРЧИГ

ОРШИЛ.....	3
НЭГ. ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ХӨГЖЛИЙН ДАВУУ БОЛОН СУЛ ТАЛУУД.....	4
1.1. Говьсүмбэр аймгийн хөгжлийн өнөөгийн байдал.....	4
1.2. Говьсүмбэр аймгийн хөгжлийн давуу болон сул талууд.....	6
ХОЁР. ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ХӨГЖЛИЙН АЛСЫН ХАРАА, ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛҮҮД.....	7
2.1. Говьсүмбэр аймгийн хөгжлийн алсын хараа.....	7
2.2. Говьсүмбэр аймгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлүүд.....	8
ГУРАВ. ХҮНИЙ ХИЙГЭЭД НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО.....	8
3.1. Ядуурал, ажилгүйдлийг бууруулах бодлого.....	8
3.2. Хүн ам зүйн бодлого.....	11
3.3. Боловсрол, соёлын хөгжлийн бодлого.....	13
3.4. Эрүүл мэндийн хөгжлийн бодлого.....	17
ДӨРӨВ. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО.....	21
4.1. Макро эдийн засгийн бодлого.....	21
4.2. Эдийн засгийн бодит салбаруудын хөгжлийн бодлого.....	22
4.2.1. Аж үйлдвэрийн хөгжлийн бодлого.....	22
4.2.2. Үйлчилгээний салбарын хөгжлийн бодлого.....	25
4.2.3. Хөдөө аж ахуйн хөгжлийн бодлого.....	28
4.2.4. Аялал жуулчлалын салбарын хөгжлийн бодлого.....	29
4.3. Дэд бүтцийн хөгжлийн бодлого.....	30
4.3.1. Зам, тээврийн хөгжлийн бодлого.....	30
4.3.2. Эрчим хүчний салбарын хөгжлийн бодлого.....	31
4.3.3. Мэдээлэл, харилцаа холбооны салбарын хөгжлийн бодлого.....	31

4.3.4. Хот байгуулалт, барилгын хөгжлийн бодлого.....	32
ТАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГО.....	33
ЗУРГАА. НУТГИЙН УДИРДЛАГА, ИРГЭНИЙ НИЙГМИЙН ОРОЛЦОО, ТҮНШЛЭЛИЙГ ХАНГАХ БОДЛОГО.....	37
ДОЛОО. ХҮРЭХ ГОЛ ҮР ДҮН, ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ МЕХАНИЗМ.....	39
7.1. Цогц бодлогыг хэрэгжүүлснээр хүрэх гол үр дүн.....	39
7.2. Цогц бодлогын хэрэгжилтийг хангах механизм.....	40
ХАВСРАЛТ	42

ОРШИЛ

1. Даяаршлын өнөө үед дэлхийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн байгальд зохицсон соёл иргэншлийг төлөвшүүлэх, дотоод, гадаад, хүчин зүйлийг үр дүнтэй ашиглах замаар улс орон хийгээд бүс, аймгийн эдийн засгийг экологийн даацад тулгуурлан хөгжүүлэх, иргэдийн аж амьдралын түвшинг дээшлүүлэхэд чиглэсэн хөгжлийн урт хугацааны цогц бодлогыг боловсруулан хэрэгжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Энэхүү шаардлагыг үндэслэн боловсруулсан Говьсүмбэр аймгийн хөгжлийн цогц бодлого нь нь ойрын ирээдүйд хүний хүчин зүйл, байгалийн баялгийг зүй зохистой ашиглан эдийн засгийн өсөлтийг түргэтгэх, нийгмийн дэвшлийг хангах талаар төрөөс баримтлах бодлого, түүнийг хэрэгжүүлэх стратеги, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлсон баримт бичиг мөн.

Монгол Улсын Ерөнхийлөгч санаачилж, манай орны эрдэмтэд, улс төрчид, иргэдийн өргөн оролцоотойгоор боловсруулан, УИХ-ын 2008 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого (2007-2021)"-д тулгуурлан "Говьсүмбэр аймгийн хөгжлийн цогц бодлого (2010-2021)"-ыг боловсруулав.

2. "Говьсүмбэр аймгийн хөгжлийн цогц бодлого (2010-2021)"-д "Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал", "Бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги (2010 он хүртэл)", "Монгол Улсын Төвийн бүсийн хөгжлийн хөтөлбөр (2015 он хүртэл)", "Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хууль" болон Монгол Улсын хөгжлийн бодлогын бусад баримт бичгүүд, бүсийн болон хөрш зэргэлдээ аймгуудын хөгжлийн бодлогын үзэл санаа, хэрэгжилтийн явц, үр дүн, залгамж чанар тусгалаа олсон болно.

3. "Говьсүмбэр аймгийн хөгжлийн цогц бодлого (2010-2021)"-д 2008-2012 онд Говьсүмбэр аймгийн ИТХ-ын баримтлан ажиллах үйл ажиллагааны чиглэл, Говьсүмбэр аймгийн Засаг Даргын 2009-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон "Говьсүмбэр аймгийн XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр", Улс, бүс нутгийн хөгжилд Говьсүмбэр аймгийн эзлэх байр суурь (2009), Говьсүмбэр аймгийн нийгэм-эдийн засгийн үзүүлэлтүүд (2003-2009), Говьсүмбэр аймгийн статистикийн эмхтгэл (2009), АМГТХЭГ-ын Геологийн мэдээллийн төвийн Ашигт малтмалын товч мэдээлэл (Говьсүмбэр аймаг), Говьсүмбэр аймгийн Чойр хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөө (2003-2020), "Чойр" эдийн засгийн чөлөөт бүсийн үйлдвэр, технологийн паркийн мастер төлөвлөгөө болон тайлбар бичиг, Говьсүмбэр аймгийн хөгжлийн нэгдсэн төлөвлөгөө, Говьсүмбэр аймгийн эдийн засгийг 2020 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр, Сүмбэр сумын хөгжлийн мастер төлөвлөгөө (2009-2019), Баянтал сумын ЗДТГ-ын үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө (2009-2011), тус сумын нийгэм эдийн засгийн үзүүлэлтүүд (2003-2009), танилцуулга, Аймгийн ХХАА-н талаар баримтлах бодлого (2007), ХХААЖДҮГ-ын 2009-2011 оны дунд хугацааны үйл ажиллагааны бизнес төлөвлөгөө, аймгийн хүн ам зүйн байдал, боловсролын салбарыг 2007-2010 онд хөгжүүлэх хөгжлийн төлөвлөгөө, нийтийн номын сангийн үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө (2010-2013), "Боржигин өв" музейн 2009-2011 оны үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө (2008), "Боржигин" чуулгын стратеги төлөвлөгөө (2008-2011), ЭМЯ-ны Эрүүл мэндийн мастер төлөвлөгөө (2006-2015), түүнийг хэрэгжүүлэх хүрээ (2006-2010) зэрэг улс, бүс нутаг, аймгийн хөгжлийн баримт бичиг, стратеги хөтөлбөрүүдэд тусгагдсан зорилтууд нэгтгэгдэн тусгагдсан болно.

4. Говьсүмбэр аймгийн урт хугацааны хөгжлийн стратегийн зорилтууд, хэрэгжүүлэх арга хэмжээний үндсэн чиглэлийг 2010-2015 он, 2016-2021 он гэсэн хоёр үндсэн үе шатаар авч үзлээ.

НЭГ. ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ХӨГЖЛИЙН ДАВУУ БОЛОН СУЛ ТАЛУУД

1.1. Говьсүмбэр аймгийн хөгжлийн өнөөгийн байдал

Говьсүмбэр аймаг нь Монгол Улсын Төвийн бүсийн зүүн өмнөд хэсэгт ХӨ 46° 57' - ХӨ 47° 02', ЗУ 107° 57', ЗУ 109° 04' хүртэл оршин байрладаг, 5.5 мянган км² нутагтай, байрлалын хувьд Өмнө талаараа Дорноговь аймгийн Даланжаргалан, зүүн, зүүн хойд талаараа Хэнтий аймгийн Дархан, Дэлгэрхаан, баруун хойд, хойд талаараа Төв аймгийн Баян, Баянжаргалан, Баянцагаан, баруун ба баруун урд талаараа Дундговь аймгийн Цагаандэлгэр, Баянжаргалан сумуудтай хиллэж эдгээр аймгийг нийслэлтэй холбосон ачаа, зорчигч тээврийн авто замтай, олон улсын транзит төмөр замын сүлжээ бүхий аймаг юм.

Тус аймгийн нутаг байгалийн бүтцийн хувьд дов толгод бүхий хээр талын бүсэд оршдог, тал хээрийн хүрэн, хүрэн цайвар хөрстэй. Нутгийн хамгийн өндөр цэг нь далайн төвшнөөс дээш 1620 метр. Уур амьсгалын хувьд хуурайдуу сэрүүвтэр. Цаг уурын олон жилийн дундаж үзүүлэлтээр 1-р сард -20.5 хэм хүртэл хүйтэрч, 7-р сард +18.6 хэм дулаардаг бөгөөд жилдээ 196.5 мм хур тунадас унадаг.

Тус аймаг нь 2009 оны байдлаар 3 сум, 10 багтай, суурин хүн амын тоо 13.3 мянга, өрхийн тоо 4.1 мянга, үүнээс нэг өрхөд 3.2 хүн, 1 хавтгай дөрвөлжин км нутагт 2.42 хүн ногдож байна.

Аймгийн хэмжээнд эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо 2009 оны байдлаар 6.1 мянган хүн, ажиллагчдын тоо 4.8 мянга. Одоогоор хөдөлмөрийн насны нийт 2158 хүн ажил эрхлээгүй байна.

Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн албанд ажил идэвхитэй хайж бүртгүүлсэн ажилгүйчүүд 157 байгаагаас эмэгтэй 96, дээд боловсролтой 5, тусгай дунд боловсролтой 8, мэргэжлийн анхан шатны боловсролтой 1, мэргэжилгүй 99 хүн байна.

Хүн амд үйлчлэх нийгмийн чиглэлийн үйлчилгээний салбарууд давуутай хөгжсөн учраас зэргэлдээ аймгуудын иргэд шилжин суурьших хандлага ажиглагдаж байна.

Ажилгүйдэл, ядуурлыг багасгахын тулд аймгийн хөгжлийн давуу тал, нөөц боломжийг бүрэн ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээг бүх талаар дэмжин хөгжүүлснээр ажлын байрыг олноор бий болгох, эдийн засгийн өсөлт, тэргүүлэх салбаруудын хөгжил, хөрөнгө оруулалтын арга хэмжээг хөдөлмөр эрхлэлтийн оновчтой бодлоготой нягт уялдуулан хэрэгжүүлэх шаардлагатай.

Тус аймагт 2009-2010 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 4 сургуульд 3000 сурагч суралцаж, 165 багш ажиллаж байгаа бөгөөд нэг багшид 29.3 сурагч ногдож байна. Суурь боловсролын хамран сургалтын бохир жин 98, бага боловсролынх 102.1, дунд боловсролынх 95.6 хувь байна.

Аймгийн 8 цэцэрлэгт 39 багш ажиллаж, нийт нэг мянган хүүхэд сурч хүмүүжиж байна.

Говьсүмбэр аймагт 2009 оны байдлаар 20 суудал бүхий нийтийн номын сан нэг ажиллаж байгаа бөгөөд уншигчдын тоо 670 хүн байна.

Говьсүмбэр аймаг 300 суудал бүхий 2 соёлын төвтэй, ажиллаж байгаа сүм хийд 2, үүнээс буддын сүм 1, христийн сүм 1 байна.

Говьсүмбэр аймагт 2009 оны байдлаар эрүүл мэндийн салбарт 41 их эмч, 2 эм зүйч ажиллаж байгаа бөгөөд нэг их эмчид 320, нэг сувилагчид 247 хүн ногдож байна.

Эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн өвчтөний тоо 2009 оны байдлаар 4.3 мянган хүн байна. Эрүүл мэндийн салбарын боловсон хүчний хангалт дутагдалтай, мэргэжлийн ур чадварын түвшин харилцан адилгүй, эмнэлгүүдийн төсөв, материаллаг баазын хангамж, хүрэлцээ хангалтгүйгээс эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээний чанар, хүртээмж шаардлагын түвшинд хүрээгүй байна.

2009 оны байдлаар тус аймагт спорт заал 9, спортоор хичээллэгчид 1787, биеийн тамираар хичээллэгчид 1932 хүн байна. Спортын цол зэрэгтэй тамирчид 393, цол зэрэгтэй шүүгчид 65, улсын цолтой бөх 1, аймгийн цолтой бөх 14, сумын цолтой бөх 24, цолтой уяачид 3 байна.

Тус аймаг 2009 онд 21 тэрбум 686 сая төгрөгийн дотоодын нийт бүтээгдэхүүн /ДНБ/ үйлдвэрлэжээ. Аймгийн эдийн засагт нааштай өөрчлөлтүүд гарч байгаа хэдий ч урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд шийдвэрлэх шаардлагатай томоохон асуудлууд цөөнгүй байна.

2009 онд орон нутгийн төсвийн орлого 1 тэрбум 597 сая төгрөг, орон нутгийн төсвийн зарлага 1 тэрбум 537 сая төгрөг байна.

Ойрын жилүүдэд ашигт малтмал олборлох, малын гаралтай түүхий эдийг боловсруулж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, мах, сүү, цагаан идээ, хүнсний ногоо боловсруулах замаар аж үйлдвэрийн салбарт өндөр өсөлтийг бий болгох шаардлагатай.

2009 онд Говьсүмбэр аймагт регистрийн санд бүртгэлтэй 183 аж ахуйн нэгж байгууллага байгаагаас одоо үйл ажиллагаа явуулж байгаа 158 аж ахуйн нэгж байгууллага байна.

Тус аймгийн нутаг дэвсгэр дээгүүр олон улсын транзит төмөр зам болон агаарын коридор дайран өнгөрдөг. Ачаа тээврийн, иргэний зорчигч тээвэрлэх бүх төрлийн даацын онгоц хөөрч буух 3 км урттай, 72 м-ийн өргөнтэй 2 зурвас бүхий онгоцны буудалтай, Налайх-Чойрын чиглэлийн 200 км хатуу хучилттай зам ашиглалтад орсон, цахилгаан эрчим хүчний дамжуулах станцтай, Шивээ-Овоогийн уурхай нүүрс олборлох 100-аас доошгүй жилийн нөөцтэй, мөн ханын материалын тоосго үйлдвэрлэхэд тохирох шаврын нөөцтэй.

Өмнөговь, Дундговь, Сүхбаатар, Хэнтий аймгуудыг шатахуунаар хангахад хүрэлцэхүйц шатах, тослох материалын агуулах, хангамжийн баазууд ажиллаж, өвс тэжээл хадгалах, тээвэрлэх өндөр хүчин чадал бүхий улсын нөөцийн газартай.

Монгол улсын хойд хилээс өмнөд хил хүртэл тавигдсан шилэн кабелийн шугамд холбогдсон, тоон АТС-ын системд шилжсэн, хөдөлгөөнт холбоо суурилагдсан, дэлхийн аль ч улс оронтой телефоноор болон интернетээр харилцах боломж бүрдсэн.

Баянтал суманд байгаа онгоцны буудал, тус бүр 80x20м-ийн багтаамжтай 40 орчим төмөр бетон агуулах, ангааруудыг ашиглан бөөний худалдааны нэгдсэн сүлжээ байгуулах болон тээвэр ложистикийн чиглэлээр ашиглах бүрэн бололцоотой.

Тус аймагт барилгын үйлдвэрлэл явуулах, Говьсүмбэр, Дундговь аймгийн нутгийг дамжин орших Хараатын ураны хүдрийг олборлох, ашиглах Шивээ-Овоогийн нүүрсний уурхайг түшиглэн нүүрс химийн үйлдвэрийг байгуулж керолин, кокс, шингэн болон бусад бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн экспортлох бололцоотой.

Аймгийн төв нь Хэрлэн голоос 90 км, Дорноговь аймгийн Халзан-Уулын рашаан сувиллаас 60 км зайд оршдог бөгөөд тус аймгийн нутаг нь орон нутгийн хамгаалалттай, өндөр хадан хясаагаар хүрээлэгдсэн, дотор эрхтний өвчнийг анагаах увьдистай "Цоорхой"-н рашаан, аргаль, янгир нутагшсан Чойрын богд уул, эртний түүхт Зүүн Чойрын хийдийн туурь, Зараа хэмээх газарт байгаа эртний түрэгийн хүн чулуун хөшөө дурсгалууд зэрэг

байгалийн болон түүхийн дурсгалт газруудыг түшиглэн аялал жуулчлал хөгжүүлэх боломжтой юм.

Говьсүмбэр аймаг нь эдийн засгийн дэд бүтэц харьцангуй сайн хөгжсөн, бизнесийн таатай орчинтой, амьжиргааны өртөг харьцангуй хямд зэрэг давуу талууддаа түшиглэн говийн бүсийн аймгуудын иргэдийн суурьшилтын нэг томоохон төв болох боломжтой.

2009 онд Говьсүмбэр аймагт 168 723 мал тоологдсоноос адуу 6946, хонь 69675, тэмээ 502, үхэр 3405, ямаа 88195 байв. Малчин өрхийн тоо 495, малчин өрхийн ам бүлийн тоо 1739, малтай өрхийн тоо 730, малтай өрхийн ам бүлийн тоо 2569, малчдын тоо 788, үүнээс эмэгтэй малчдын тоо 403 байна.

Тус аймаг 2009 онд 47.3 га газар тариалалт хийснээс 18.5 га-д төмс, 5.8 га-д хүнсний ногоо, 23.1 га-д тэжээлийн ургамал тариалж, 22.3 тн хүнсний ногоо, 96.9 тн төмс, 0.8 тн тэжээлийн ургамал хураан авчээ.

Говьсүмбэр аймаг нь цаашид хөгжлийн нөөц, боломжид тулгуурлан уул уурхай, боловсруулах аж үйлдвэр, эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан, аялал жуулчлал, зарим ашигт малтмалын олборлох болон боловсруулах үйлдвэрүүдийг байгуулан хөгжүүлснээр аймгийн эдийн засгийг түргэн хурдацтай хөгжүүлэн ажилгүйдэл, ядуурлыг бууруулж, аймаг өөрөө биеэ даан нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлуудаа шийдвэрлэх бүрэн боломжтой юм.

1.2. Говьсүмбэр аймгийн хөгжлийн давуу болон сул талууд

Говьсүмбэр аймгийг 2010-2021 он хүртэл хөгжүүлэх цогц бодлогод хөгжлийн дор дурдсан давуу болон сул талуудыг тооцон үзэв. Үүнд:

Хөгжлийн давуу талууд:

- Олон улсын Транзит төмөр зам болон агаарын коридортой;
- Ачаа тээврийн болон иргэний зорчигч тээвэрлэх бүх төрлийн даацын онгоц хөөрч буух 3 км урттай, 72 м-ийн өргөнтэй 2 зурвас бүхий онгоцны буудалтай;
- Монгол улсын хойд хилээс өмнөд хил хүртэл тавигдсан шилэн кабелийн шугамд холбогдсон;
- Тоон АТС-ын системд шилжсэн, хөдөлгөөнт холбоо суурилагдсан, дэлхийн аль ч улс оронтой телефоноор болон интернетээр харилцах боломжтой;
- Нийслэл Улаанбаатар хоттой хатуу хучилттай авто замаар холбогдсон;
- Төвийн эрчим хүчний системд холбогдсон, аймгийн төвдөө цахилгаан эрчим хүчний дамжуулах станцтай, цахилгаан хангамж сайтай.
- Усанд агуулагдах төмрийн хэмжээг багасгасан нөхцөлд үйлдвэрлэлийн буюу ундны усны нөөцтэй;
- Мал эмнэлэг, ариун цэврийн иж бүрэн тоноглогдсон лабораторийг ашиглан Төвийн бүсийн хүнсний бүтээгдэхүүний шинжилгээ хийх чадавхи бүрдсэн;
- Шивээ-Овоогийн уурхай нүүрс олборлох 100-аас доошгүй жилийн нөөцтэй;
- Ханын материалын тоосго үйлдвэрлэхэд тохирох шаврын нөөцтэй;
- Өмнөговь, Дундговь, Сүхбаатар, Хэнтий аймгуудын шатахууны хэрэгцээг хангах, шатах, тослох материал тээвэрлэх, агуулах боломж бүхий Нефть хангамжийн газартай;
- Өвс тэжээл хадгалах өндөр хүчин чадал бүхий улсын нөөцийн газартай;
- Баянтал суманд байгаа онгоцны буудал, нэг нь 80х20м-ийн багтаамжтай 40 орчим төмөр бетон агуулах, ангааруудыг ашиглан бөөний худалдааны нэгдсэн сүлжээ байгуулах боломжтой;

- Говьсүмбэр, Дундговь аймгийн нутгийг дамжин орших Хараатын ураны хүдрийг ашиглах, олборлох боломжтой;
- Шивээ-Овоогийн нүүрсний уурхайг түшиглэн нүүрс химийн үйлдвэр хөгжүүлэх, керолин, кокс, шингэн болон бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэж экспортлох боломжтой;
- Байгалийн болон түүхийн дурсгалт газруудыг түшиглэн аялал жуулчлал хөгжүүлэх бололцоотой;
- Орон нутгийн өмчит цөм сүрэгтэй;
- Орон сууцны хүрэлцээ, хангамж сайтай;
- Говьсүмбэр аймаг нь давуу талууддаа түшиглэн говийн бүсийн аймгуудын иргэдийн суурьшилтын нэг томоохон төв болох боломжтой.

Хөгжлийн сул талууд:

- Эдийн засгийн бодит салбарын бүтэц жигд биш;
- Мах, сүүний үйлдвэрлэлийн түүхий эдийг тасралтгүй нийлүүлэх эрчимжсэн аж ахуй сул хөгжсөн;
- Арьс, ноос зэрэг малын гаралтай түүхий эд болон бусад төрлийн боловсруулах үйлдвэргүй;
- Бэлчээрийн талбай багатай, бэлчээрийн даац хэтэрснээс болж бэлчээр ихээхэн талхлагдсан;
- Газар тариалан сул хөгжсөн, энэ салбарын аж ахуй нэгжүүдийн үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, технологи хоцрогдсон, мөн байгаль цаг агаараас ихээхэн хамааралтай;
- Газрын гадаргын болон хөрсний усны хомсдолтой;
- Боловсролын салбарын чанарын түвшин сул, энэ талын тулгамдсан асуудлуудыг яаралтай шийдвэрлэх шаардлагатай;
- Аймгийн эрүүл мэндийн байгууллагуудын үзүүлж буй үйлчилгээ, эмчилгээ-оношлогооны чанар, тоног төхөөрөмжийн хангамж хүрэлцээ сайжирч байгаа хэдий ч санхүүгийн чадавхи хязгаарлагдмал, сум болон өрхийн эмнэлгийн үйлчилгээний чанар хүртээмж жигд бус байгаа;
- Соёл, урлаг, спортын байгууллагын үйл ажиллагааны материаллаг бааз хангалттай бэхжээгүй, мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай, иргэдэд үзүүлэх соёлын үйлчилгээ байнгын бус, байгууллагууд чиг үүргээ биелүүлэхэд нэн шаардлагатай стандартын барилга байгууламжгүй;
- Хүн ам цөөн, боловсон хүчин дутагдалтай;
- Ажилгүйдэл ядуурлын асуудал их;

ХОЁР. ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ХӨГЖЛИЙН АЛСЫН ХАРАА, ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛҮҮД

2.1. Говьсүмбэр аймгийн хөгжлийн алсын хараа

Говьсүмбэр аймгийн хөгжлийн 2021 он хүртэлх **алсын хараа нь** хүний хөгжилд тулгуурласан, эдийн засгийн эрчимтэй өсөлтийг хангасан, хүн амын амьдралын түвшинг тууштай дээшлүүлсэн, өөрөө өөрийгөө тэтгэдэг, оновчтой бүтэц бүхий, мэдлэгт суурилсан эдийн засагтай, хүн амын зохистой суурьшил бүхий Төвийн бүсийн тэргүүлэх аймаг болоход оршино.

2.2. Говьсүмбэр аймгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлүүд

Говьсүмбэр аймгийн хөгжлийн цогц бодлогыг дараах зургаан тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлнэ.

1. Мянганы хөгжлийн зорилтуудыг тус аймагт хэрэгжүүлж, хүнийг бүх талаар хөгжүүлэх.
2. Дэлхийн болон дотоодын зах зээлд өрсөлдөх чадвартай, хувийн хэвшилд тулгуурласан экспортын баримжаатай үйлдвэрлэл, үйлчилгээг эрчимтэй хөгжүүлж, аймгийн эдийн засгийг олон талтай, мэдлэгт суурилан хөгжүүлэх.
3. Зам тээвэр, эрчим хүч, мэдээлэл холбооны дэд бүтцийг эрчимтэй хөгжүүлж, хөгжлийн таатай орчин бүрдүүлэх.
4. Аймгийн төв, бичил бүс, сумдын төв, суурингуудыг хөгжүүлж хот, хөдөөгийн хөгжлийн түвшний ялгааг багасгах.
5. Аялал жуулчлалын салбарыг аймгийн эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болгон хөгжүүлэх.
6. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон чадавхийг бий болгон экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах.

ГУРАВ. ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ХҮНИЙ ХИЙГЭЭД НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Говьсүмбэр аймгийн хөгжлийн 1 дэх тэргүүлэх чиглэлийн хүрээнд аймагт ядуурал, ажилгүйдлийг тууштай бууруулан иргэдийн амьдралын түвшинг тасралтгүй дээшлүүлж, “Гэр бүл, хүүхдийн цогц хөгжил” үндэсний хөтөлбөрийн хүрээнд гэр бүлийг хөгжүүлэн, хүн ам зүйн оновчтой бодлогыг хэрэгжүүлж, хүн амын боловсрол, соёл, эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг эрс сайжруулна.

3.1. Ядуурал ажилгүйдлийг бууруулах бодлого

Үндэслэл: Төвийн бүсийн хувьд амьжиргааны доод түвшинг нэг хүнд сард ногдохоор авч үзвэл 91200 төгрөг, ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, тухайлбал, ядуурлын хамралтын хүрээ 30,7 хувь, ядуурлын гүнзгийрэлт 8,4 хувь, ядуурлын мэдрэмж 3,3 хувьтай байна. Төвийн бүсэд хөдөлмөр эрхэлж буй 181.4 мян.хүн байгаагийн 2.3 хувь нь буюу 4.2 мян.хүн нь тус аймагт ажиллаж байна.

Тус аймагт зах зээлд ажиллах хүчний өрсөлдөх чадвар муу, мэргэжилгүй ажилгүйчүүдийн эзлэх хувь өндөр, ажилгүйдлийн үргэлжлэх хугацаа урт байгаа, иргэдийн бизнес эрхлэн бие даан амьдрах мэдлэг, дадлага, туршлага дутмаг, бэлэнчлэх сэтгэлгээнээс түргэн салж чадахгүй байна. Орон нутагт үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахад шаардагдах хөрөнгө санхүүгийн дутагдалтай, мэргэжлийн боловсон хүчнүүд нь өөрсдийн мэдлэг, ур чадварыг ашиглан орон нутгийн хөгжилд дорвитой хувь нэмэр оруулахуйц үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах талаар шинийг санаачилж ажиллахгүй байгаа зэргээс шалтгаалан ажилгүйдэл, ядуурал төдийлөн буурахгүй байна.

Аймгийн хөгжлийн давуу талыг бататгаж, сул талыг саармагжуулах замаар нөөц боломжийг бүрэн дүүрэн ашиглах, үйлдвэрлэл, үйлчилгээг бүх талаар дэмжин ажлын байрыг олноор бий болгож ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, эдийн засгийн өсөлт, тэргүүлэх салбаруудын хөгжлийг хөрөнгө оруулалттай нягт уялдуулах, иргэдийн

боловсрол, соёлын түвшинг дээшлүүлэх, түүнчлэн нутгийн захиргаа, аж ахуйн удирдах ажилтнуудын удирдах болон мэргэжлийн ур чадварыг сайжруулах замаар хөдөлмөр эрхлэлтийн оновчтой бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай.

Нэгдүгээр үе шат (2010-2015 он):

Стратегийн зорилт 1. Хүний хөгжлийг бүх талаар дэмжиж, ядуу өрхийн амьжиргааг тогтвортой дээшлүүлж, байнгын болон улирлын ажлын байрыг нэмэгдүүлэн ажилгүйдлийн түвшинг 4,0 хувь хүртэл бууруулж, нийгмийн баялгийг бүтээхэд оролцдог иргэдийн тоог өсгөнө.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Говьсүмбэр аймгийн хөгжлийн цогц бодлоготой уялдуулан “Эдийн засгийн өсөлтийг дэмжих, ядуурлыг бууруулах дунд хугацааны хөтөлбөр” боловсруулж, сумдын хөгжлийн бизнесийн орчныг сайжруулах мастер төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх;
- Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн судалгааг өргөжүүлж, ажил олгогч, ажил хийгчид, мэргэжлийн сургалтын байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах;
- Ажил идэвхтэй эрж буй хөдөлмөрийн насны иргэд болон ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэд, тухайн онд ЕБС-ийн 9,11-р анги төгссөн, түүнчлэн хугацаат цэргийн албанаас халагдсан ажил, сургуульгүй иргэдийг хөдөлмөрийн зах зээлд эрэлт хэрэгцээтэй мэргэжил олгох сургалтад хамруулах хөтөлбөрийг хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх;
- Ядуу өрхийг малжуулах, газар тариалан эрхлүүлэх зэргээр өмчтэй болгож хөдөөд өрхийн үйлдвэрлэл хөгжүүлэх замаар орлогыг нь нэмэгдүүлэх;
- Ажлын байр шинээр бий болгосон аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг дэмжин жижиг, дунд үйлдвэрлэл хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээл, банкны зээл, төсөлд хамруулах;
- Эдийн засгийн өсөлт, хөрөнгө оруулалтын арга хэмжээтэй нягт уялдуулан ажлын байрыг тууштай нэмэгдүүлж, ажилгүйдлийн түвшинг 4 хувиас дээшгүй байлгах;
- Нийгмийн эмзэг хэсгийн хүн амд зориулан ядууралтай тэмцэх, иргэний боловсрол олгох "төв" байгуулж бүлэг, нөхөрлөлд түшиглэсэн сургалт явуулах, тэдгээрт зориулан ажлын байр шинээр бий болгосон ажил олгогч болон төсөл хэрэгжүүлэгчдийг бодлогоор дэмжих;
- Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ, дэд бүтэц, аялал жуучлалын салбарт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих;
- Ядуурлыг бууруулах зорилгоор хэрэгжүүлж байгаа олон улсын төсөл, хөтөлбөрүүдийн үйл ажиллагааг орон нутагт идэвхжүүлэх;
- Хөдөлмөр эрхлэлтийн сан болон бусад хөтөлбөр, төслүүдийн хүрээнд хугацааны хувьд байнгын, үнэлгээний хувьд цалин өндөртэй ажлын байрыг бий болгох;
- Байгаль орчныг хамгаалах, ялангуяа цөлжилттэй тэмцэх, ойн зурвас байгуулах, хөрс, бэлчээрийг хамгаалах, худаг ус гаргах ажилд хөдөлмөр эрхлээгүй иргэдийг өргөнөөр татан оролцуулах.

Гарах үр дүн: Ажлын байрыг шинээр бий болгож, ажилгүйдлийн түвшин 4 хувиас доошгүй буурсан байна.

Стратегийн зорилт 2. Аймгийн хүн амыг тогтвортой ажлын байраар ханган, орлогын байнгын эх үүсвэрийг нэмэгдүүлснээр иргэдийн амьжиргааны түвшинг тууштай дээшлүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн бүртгэл, мэдээлэл, зохион байгуулалтыг сайжруулж аймгийн нэгдсэн сүлжээ байгуулах замаар хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн системийг бий болгох;
- Мал аж ахуй, газар тариалан эрхлэгчдийн 40 хүртэл хувийг малчны бүлэг, хоршоо, нөхөрлөл, өрх/фермер/-ийн аж ахуй зэрэг хамтын аж ахуйд татан оролцуулж, түүхий эдийг ангилах, савлах, анхан шатны боловсруулалт хийж эхлэх замаар түүхий эдийн үнэлэмжийг нэмэгдүүлж тэдний бодит орлогыг өггсөх;
- Мал аж ахуй, газар тариалан, хадлан, тэжээл бэлтгэх чиглэлээр хоршоо, нөхөрлөл байгуулахыг бодлогоор дэмжих;
- Үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ тарих, гахай, тахиа үржүүлэх ажлыг сум бүрт хэрэгжүүлэх;
- Иргэдэд төрөл бүрийн ажлын дадлага, үр чадвар олгох богино хугацааны сургалт зохион байгуулах;
- Сүмбэр суманд мэргэжлийн түр сургалтын төв байгуулах;
- Нийтийг хамарсан ажилд хөдөлмөр эрхлээгүй залуучууд, нийгмийн эмзэг бүлгийн иргэдийг өргөнөөр хамруулах замаар түр ажлын байр бий болгох;
- Усны эх булаг, ховордсон ан амьтдыг хамгаалах, худаг, булаг шандыг тохижуулах ажилд орон нутгийн иргэдийг өргөн хамруулан эдийн засгийн хөшүүргээр урамшуулах;
- Баянтал, Сүмбэр суманд тэжээлийн аж ахуйг хөгжүүлэх.

Гарах үр дүн: Байнгын ажлын байр, орлогын эх үүсвэр бүхий иргэдийн тоо нэмэгдэж, аймгийн нийт хүн амын амьжиргааны түвшин дээшилсэн байна.

Стратегийн зорилт 3. Аймгийн нийгмийн халамж үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах, иргэдийн нийгмийн хамгааллын тогтолцоог боловсронгуй болгох, иргэдэд халамжийн үйлчилгээ үзүүлэх, бүтэн өнчин, тэнэмэл хүүхдийг асран хамгаалах, боловсрол олгоход чиглэсэн аймаг, сумдын "нийгмийн халамжийн сан" байгуулан ажиллана.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Халамжийн үйлчилгээнд хамрагдах өрх, иргэдийг сумдын амьжиргааг дэмжих зөвлөлөөр хэлэлцүүлэн бүрэн тодорхойлсноор аймаг, сумын төвд нийгмийн халамжийн бүх төрлийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах;
- Нийгмийн даатгалд хамрагдах хүрээг тэлэх замаар тэтгэврийн суурь даатгалын тогтолцоонд аймгийн хүн амыг бүрэн хамруулах;
- Бүтэн өнчин, тэнэмэл, нэн ядуу өрхийн хүүхдүүдийг байрлуулах, хооллох, сургалт явуулах халамжийн төв байгуулан ажиллуулах;
- Ядуу, орон гэргүй иргэдэд гэр, хашаа, орон сууц худалдан авах, барих, өргөтгөх боломж олгох зорилгоор тэднийг орон сууцны зээлийн үйлчилгээнд хамруулах;
- Хөдөлмөр эрхлээгүй хүмүүс, нийгмийн эмзэг бүлгийн иргэдийг дэд бүтэц, нийтийн аж ахуй болон нийтийн эзэмшлийн зам талбай, ногоон байгууламжийн тохижилт, үйлчилгээний ажилд гэрээгээр ажиллуулж байх;
- Хүүхэд хамгааллын "Хамтарсан баг"-ийг аймгийн хэмжээнд байгуулах;

- Хүүхдийг гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор насанд хүрээгүй хүмүүсийн хэрэг эрхлэх хороо байгуулах;
- Олон нийтэд түшиглэсэн хүүхэд хамгааллын үйлчилгээг холбогдох байгууллагуудаас дэмжлэг авч өргөжүүлэх, хүүхдийн төлөө бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад тэдний санаа бодол, хүүхдийн бодитой оролцоог дэмжиж ажиллах;
- Хүүхдийн эсрэг хүчирхийллийн ойлголт мэдлэгийг дээшлүүлж, сурталчлах, хүчирхийлэлд өртсөн, өртөж болзошгүй хүүхдүүдийн эрхийг хамгаалах, тэднийг нийгэмшүүлэх, энэ үйл хэрэгт иргэд, байгууллагыг татан оролцуулах;
- Орон нутагт Хүүхдийн оролцооны байгууллагын үйл ажиллагааг өргөжүүлэх, тэдний дуу хоолойг орон нутгийн удирдлагуудад хүргэж ажиллах;
- Хүүхэд багачуудыг гэр бүлд нь зөв, эерэг аргаар хүмүүжүүлэх сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах;
- Хүүхдийн төлөө хэлтсийн дэргэд “хүүхдийн - итгэлийн” утас ажиллуулж, утсаар ирсэн мэдээллийг цаг тухайд нь шийдвэрлэж, хариу өгөх ажлыг зохион байгуулах.

Гарах үр дүн: Иргэдэд үзүүлэх нийгмийн хамгаалал, халамж үйлчилгээний хүртээмж, чанар сайжирч, халамжийн үйлчилгээнд эмзэг бүлгийн хүмүүс бүрэн хамрагдаж, тэдний амьжиргааны түвшин дээшилсэн байна.

Хүүхэд хамгаалах ажилд иргэд, байгууллагын болон хүүхдийн бодит оролцоо, сайжирч хүүхдийн эрх зөрчигдөх явдал багассан байна.

Хоёрдугаар үе шат (2016-2021он):

Стратегийн зорилт 1. Ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн адил тэгш оролцоог хангана.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Ядуурлыг бууруулах, ард иргэдийн амьжиргааг дээшлүүлэхэд чиглэсэн төсөл, хөтөлбөрийн асуудлаар аймгийн нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх;
- Мал аж ахуй, газар тарилан эрхлэгчдийн дийлэнх хэсгийг хамарсан малчны бүлэг, хоршоо, нөхөрлөл, өрх/фермер/-ийн зэрэг хамтын аж ахуй байгуулах, түүхий эдийг үйлдвэрийн аргаар боловсруулах чиглэлийн жижиг, дунд үйлдэрлэлийг хөгжүүлж тэдний бодит орлогыг нэмэгдүүлэх;
- Аялал жуулчлал хөгжүүлэх, байгаль хамгаалах, нөхөн сэргээх зэргээр хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхийг бүх талаар дэмжих.

Гарах үр дүн: Ажилгүйдэл болон амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэдийн эзлэх хувь хэмжээ буурсан байна.

Стратегийн зорилт 2. Нэн ядуу иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд чиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээг боловсронгуй болгоно.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Бүтэн өнчин, тэнэмэл болон нэн ядуу өрхийн хүүхдийг байрлуулах, хооллох, сургалт явуулах халамж үйлчилгээний төвийн үйл ажиллагааг шинэчлэн эрчимжүүлж тэдэнд амьдралын арга ухаан зааж сургах;

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх дэмжлэг, үйлчилгээний нэр төрөл, хамрах хүрээ, хүртээмжийг эрс нэмэгдүүлэх;
- Өндөр настанд үзүүлэх тусламж, хөнгөлөлтийг сайжруулах, өрхийн тэтгэмжийн шинэ төрлүүдийг бий болгох;
- Хүүхдийн эрхийг дээдэлсэн, хүүхдийн эрхийн зөрчилгүй гэр бүл, сургууль, орон сууц, хамт олон, баг, хороо шалгаруулан урамшуулж сурталчлах ажлыг зохион байгуулах.

Гарах үр дүн: Нэн ядуу иргэд, өндөр настнуудад үзүүлэх халамж үйлчилгээний төрөл шинэчлэгдэж, хүртээмж чанар нь сайжирсан байна.

3.2. Хүн ам зүйн бодлого

Үндэслэл: Говьсүмбэр аймаг 2009 оны жилийн эцсийн байдлаар 14.135 хүн амтай, түүний 39.9 хувь нь 16-35 насны залуучууд, 5331 буюу 37.7 хувь нь хүүхэд байна. Хүүхдийг насны бүлгээр нь авч үзвэл 0-4 насны 1534 хүүхэд, 5-9 насны 1193 хүүхэд, 10-14 насны 1402 хүүхэд, 15-18 насны 1202 хүүхэд байна. Аймгийн хэмжээнд хүнд нөхцөлд амьдарч байгаа хөгжлийн бэрхшээлтэй 53, нэн ядуу өрхөд 508 хүүхэд, хөдөлмөр эрхлэгч 39 хүүхэд, бүтэн өнчин 16 хүүхэд, хагас өнчин 171 хүүхэд байна. Нийт хүн амын 37.7 хувь нь хүүхэд байна. Энэ нь нийт хүүхдийн 14.7 хувийг эзлэж байна. Хүн амын 50,5 хувь нь эмэгтэй, 49.5 хувь нь эрэгтэй. Нийт өрхийн 58.7 хувь нь аймгийн төвд, 23.3 хувь нь сумын төвд, 18.0 хувь нь хөдөө багт амьдардаг бөгөөд аймгийн хүн амын

Говьсүмбэр аймгийн 1000 хүнд ногдох төрөлт 29.3, нас баралт 6.6, цэвэр өсөлт 22.7, гэрлэлт 23.1, гэр бүл цуцлалт 1.2, хүүхэд үрчлэлт 1.3 байна. Хүн амын дундаж наслалт 69.83 байна. 2009 оны байдлаар Говьсүмбэр аймгийн хүний хөгжлийн индекс 0.748, хүн амын дундаж наслалтын индекс 0.747, хүн амын боловсролын түвшний нэгдсэн индекс 0.957, нэг хүнд ногдох ДНБ-ний (валютын худалдан авах чадварын паритет ам.доллар) индекс 0.539 байна.

Мөн оны Говьсүмбэр аймгийн 16 хүртэлх насны 4 ба түүнээс дээш насны хүүхэдтэй өрхийн тоо 52, өрх толгойлсон эмэгтэйчүүдтэй өрхийн тоо 678, төрөлт 384, нас баралт 87, цэвэр өсөлт 297, гэрлэлт 206, гэр бүл цуцлалт 11, үрчлэгдсэн хүүхдийн тоо 17 байна.

Нэгдүгээр үе шат (2010-2015 он):

Стратегийн зорилт 1. Аймгийн хүн амын жилийн дундаж өсөлтийг тууштай нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- “Гэр бүл, хүүхдийн цогц хөгжил” аймгийн дэд хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх;
- Аймаг, сумдын хөгжлийн бодлого, төлөвлөлтөд хүн ам зүйн хүчин зүйлсийг оновчтой тусгаж хэрэгжүүлэх;
- Залуу гэр бүл болон шинээр төрсөн хүүхдийг дэмжих сан байгуулан ажиллуулах;
- Аймгийн төв, сумдын эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэх замаар хүн амыг өсгөж, иргэд төрсөн нутагтаа тогтвор суурьшилтай, ая тухтай амьдрах, ажиллах нөхцөл бүрдүүлэх;
- Хүн амын эмзэг бүлгийн хөгжлийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх;
- Өрх нэг бүрээр угийн бичиг хөтлүүлж занших;

- Хүн амын дундаж наслалтыг 70-д хүргэх;
- Аймгийн хүн амын гадагш чиглэсэн шилжих хөдөлгөөнийг сааруулах.
- Эцэг эхийн хараа хяналтаас гарсан хүүхдүүдэд асран хамгаалагч тогтоолгох ажлыг тогтмол зохион байгуулах;
- Хөдөө орон нутгаас шилжин ирж байгаа хүүхдийн талаарх мэдээ, мэдээллийг тогмол авч ажиллах.

Гарах үр дүн: Аймгийн хүн амын жилийн тогтвортой өсөлтийг дэмжсэн нөхцөл бүрдсэн байна.

Стратегийн зорилт 2. Аймгийн хүн амыг ажлын байраар хангах асуудлыг бүрэн шийдвэрлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн сургалтын материаллаг бааз, сурах орчин, хөтөлбөрийг шинэчлэн, суурь болон бүрэн дунд боловсрол эзэмшсэн хүмүүсийг хамруулах;
- Ажилгүйдлын даатгалд хамрагдаагүй, удаан хугацаагаар ажилгүй байгаа, нийгмийн эмзэг бүлгийн иргэд, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэд болон тухайн онд ЕБС төгссөн ажил, сургуульгүй үлдсэн хүүхдүүдэд хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн мэргэжил олгох болон мэргэшлийн ур чадварын сургалтад бүрэн хамруулах арга хэмжээ авах;
- Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагыг хангасан ажлын байр бий болгох нөхцөлийг бүрдүүлэх.

Гарах үр дүн: Ажил идэвхтэй эрж буй иргэдийн дотор хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжил эзэмшсэн хүний эзлэх хувь хэмжээ нэмэгдэж, ажил хөдөлмөр эрхлэх боломж бүрдэнэ.

Хоёрдугаар үе шат (2016-2021он):

Стратегийн зорилт 1. Хүн амын жилийн дундаж өсөлтийг улсын дундаж түвшинд хүргэнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Хүн ажиллаж амьдрах таатай нөхцөл бүрдүүлж, хүний хөгжлийг бүх талаар хурдасгах;
- Аймгийн эдийн засгийн өсөлтийг түргэсгэн ажлын байрны хангамжийг сайжруулах замаар иргэдийн гадагш чиглэсэн шилжих хөдөлгөөнийг эрс бууруулах;
- Төрөлтийг дэмжих зорилгоор өрхийн орлогод ногдох албан татварт хөнгөлөлт үзүүлэх, өрхийн хүүхдийн тоо, насны ялгааг харгалзан тэтгэлэг олгох зэрэг арга хэмжээний хамрах хүрээг өргөтгөх;
- Хүн ажиллаж амьдрах нийгэм, эдийн засаг, орчин ахуйн таатай нөхцөлийг бүрдүүлэх;
- Аймаг сумын түвшинд хүн амын бичиг үсэг үл мэдэх явдлыг арилгаж, насан туршдаа боловсрол, мэдлэгээ дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх.

Гарах үр дүн: Аймгийн хүн амын дундаж өсөлт тогтворжиж, улмаар хүн амын тоо нэмэгдэх нөхцөл бүрдэнэ.

Стратегийн зорилт 2. Хүнийг хөгжүүлэх боломжийг бүрэн дүүрэн ашиглах замаар аймгийн хэмжээнд хүний хөгжлийн индексийн дундаж үзүүлэлтийг улсын дундаж түвшинд хүргэнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Аймаг, сумын түвшинд хүн амын орлогыг нэмэгдүүлэх, боловсролын түвшинг дээшлүүлэх, эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах арга хэмжээнүүдийг тууштай үргэлжлүүлэн хэрэгжүүлэх;
- Албан ба албан бус боловсролын тогтолцоог боловсронгуй болгож, бүх шатны боловсролын хүртээмж, чанарыг сайжруулах;
- Үйлдвэрлэлийн салбарын бүтэц, өсөлттэй уялдуулан мэргэжилтэй ажилтан бэлтгэх;
- Нийт малчдыг зайны сургалтад хамруулах оновчтой арга, хэлбэрийг сонгон нэвтрүүлэх.

Гарах үр дүн: Аймгийн хэмжээнд хүний хөгжлийн индекс улсын дундаж түвшинд хүрсэн байна.

3.3. Боловсрол, соёлын хөгжлийн бодлого

Үндэслэл: Говьсүмбэр аймагт 2009-2010 оны хичээлийн жилд ЕБС-ийг өдрөөр төгсөгчид 300, нэгдүгээр ангид элсэгчид 300, дотуур байранд амьдарч байгаа хүүхэд 80, малчин хүүхдийн тоо 42, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид 166 байна.

Боловсролын салбарын шинэчлэлийг гүнзгийрүүлж, бүх шатны сургуулиудын сургалтын чанарыг сайжруулах шаардлагатай.

Тус аймагт номын сангийн зориулалтын барилга барих, ажиллагсдын тоог ахиулан мэргэжлийн байгууллагын түвшинд номын сангийн үйл ажиллагааг явуулах шаардлагатай.

2009 онд аймагт 56 мэргэжлийн урлагийн тоглолт явагдаж үзэгчдийн тоо 13800-д хүрчээ.

Тус аймгийн "Боржигин өв" музей нь 3 ажилтантай, 3 танхим бүхий 120 кв.м. талбайтай, нийт үзмэрийн тоо 497 байгаа бөгөөд үзэгчдийн тоо 1000-д хүрчээ. Цаашид музейн барилга шинээр барих, музейн мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, музейн үзмэрийн тоог нэмэгдүүлэх, Боржигин түмний түүх соёлын өвийг судлах, нээн илрүүлэх замаар музейн үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд явуулах шаардлагатай.

Мөн тус аймагт 300 суудал бүхий 2 соёлын төв ажиллаж байна. Зориулалтын барилга барих, боловсон хүчин, материаллаг баазыг нэмэгдүүлж, иргэд олон түмэнд соёлын үйлчилгээг түргэн шуурхай хүргэх шаардлагатай.

Цаашид соёл, урлагийн байгууллагуудыг зориулалтын барилга байгууламжтай болгож, материаллаг баазыг нь бэхжүүлэх, Боржигин чуулгын урын санг баяжуулж, сонгодог, орчин үеийн болон уламжлалт ардын урлагтай хослуулан мэргэжлийн өндөр түвшинд уран бүтээлийг туурвиж хөгжүүлэх нь нэн тэргүүний тулгамдсан асуудал болж байна. Музей, номын санг төрөлжүүлэх, төрөлжсөн эрдэм судлалын ажлын орон тооны бус судлаачдын багтай болгох, сумдын соёлын төвийн үйлчилгээг сайжруулах, иргэдэд үзүүлэх соёл, урлагийн үйлчилгээний чанарыг шаардлагын хэмжээнд хүргэх, биет болон биет бус соёлын өвийг хадгалах, хамгаалах, сэргээж дотоод, гадаадад сурталчлах, ЕБС-ийг түшиглэн ардын уламжлалт урлагийн сургалтуудыг нээн хичээллүүлэх, түүх соёлын

дурсгалт зүйлсийг хадгалах хамгаалах, сэргээн засварлах ажлыг цогц байдлаар шийдвэрлэх шаардлагатай.

Мэргэжлийн урлагийн байгууллагын орон тоог нэмэгдүүлэх, мэргэжлийн боловсон хүчнээр хангаж, тогтвор сууршилтай ажиллах нөхцөлийг бий болгох, аймгийн "Боржигин Чуулга"-ыг цаашид бүс нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулах мэргэжлийн урлагийн цогцолбор болгох шаардлагатай.

Нэгдүгээр үе шат (2010-2015 он):

Стратегийн зорилт 1. Суралцагчдад хүртээмжтэй, чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг зөвхөн сургуулиар үл хязгаарлан, сургуулийн өмнөх, зайны, албан бус боловсрол олгох болон мэргэжил эзэмшүүлэх сургалтаар цогц олгоно.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Сургалтын байгууллагын бүтэц хэв шинж, зохион байгуулалт, менежментийг боловсронгуй болгож, үйлчилгээний чанарыг сайжруулах;
- Боловсролын байгууллагуудын хөгжлийг дэмжиж, ЕБС-ийг 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжүүлэх;
- Суралцагчдад чанартай боловсрол эзэмших тэгш боломж олгох, орчин нөхцөл бүрдүүлэх, сурах эрхээ эдлэхэд нь дэмжлэг үзүүлэх;
- Оюуны багтаамж ихтэй, өндөр технологи эзэмшүүлэх зорилгоор залуучуудыг өндөр хөгжилтэй орнуудад сургах;
- Их, дээд салбар сургууль нээн ажиллуулж орон нутагт дээд боловсролтой, инженер-техникийн мэргэжилтэн бэлтгэх;
- Дэлхийн шилдэг боловсролын эталонд тооцогддог Кембрижийн боловсролын тогтолцоог нэвтрүүлэх
- Хүн амд тасралтгүй боловсролын үйлчилгээ үзүүлэх албан бус боловсрол болон насанд хүрэгчдын боловсролын үйлчилгээний сургалтын орчин, нөөцийн чадавхи, чанар, хүртээмжийг дээшлүүлэх;
- МСҮТ-ийн сургалтын чанарыг сайжруулан, мэргэжлийн сургалт, техникийн боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлэх замаар хөдөлмөрийн зах зээлд эрэлт хэрэгцээ бүхий мэргэжилтэй ажиллах хүчин нийлүүлэх;
- Боловсролыг хөгжүүлэхэд төр, олон нийтийн болон мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоог нэмэгдүүлж, тэдний оруулсан хувь нэмрийг хөхиүлэн дэмжих;
- Аж ахуйн нэгж байгууллага иргэдийн өмчид суурилсан төрийн өмчийн бус боловсролын байгууллага, МСҮТ-ийн үйл ажиллагааг дэмжих;
- МСҮТ-ийг Ази Номхон Далайн бүсэд магадлан итгэмжлэгдсэн Уул, уурхайн политехник коллеж болгон, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн чанартай мэргэжил, боловсрол эзэмшүүлэх;
- Бүх нийтийн боловсрол, мэргэжлийн тасралтгүй чанарыг хангахын тулд албан бус боловсрол, зайны сургалтын тогтолцоо бүрдүүлж, энэ ажилд бүх нийтийн нөөц бололцоог өргөн ашиглах;
- ЕБС-д сургууль завсардсан хүүхдүүдэд боловсрол нөхөн олгох бүх хэлбэрийг дэмжих;
- Бүх нийтийн монгол хэл, бичгийн боловсролыг тасралтгүй дээшлүүлж, бүх шатны сургуульд эх хэлээ эзэмших нөхцөлийг бүрдүүлэх;
- Англи хэлийг бүх нийтийн голлох гадаад хэл болгох;

- Төрийн бус өмчийн сургуулийг аймаг, сумын төвд байгуулан ажиллуулахад дэмжлэг үзүүлэх;
- Сургууль, эцэг эх, байгууллага, олон нийтэд түшиглэсэн боловсролын олон хувилбарт сургалтыг дэмжих;
- Спортын дунд сургуультай болох;
- Хүнд нөхцөлд амьдарч байгаа болон ерөнхий боловсролын сургуульд олон хүүхэд нь сурч байгаа өрхийн хүүхдэд үзүүлэх хувцас, хичээлийн хэрэглэл, хоол хүнсний дэмжлэгийг өргөжүүлэх;
- Нийгмийн эмзэг бүлгийн болон орлого багатай айл өрхийн хүүхдийн боловсрол эзэмшихэд туслах, дэмжлэг үзүүлэх, сургууль завсардалтыг бууруулан хамран сургалтыг нэмэгдүүлэх;
- Хүүхдийг амьдрах арга ухаанд сургах чиглэлээр төсөл хэрэгжүүлэх;
- Хүүхдийн төлөө хэлтсийн дэргэд “Хүний эрхийн танхим”-ыг ажиллуулж аймаг, орон нутгийн лекторуудаар хүчирхийлэлд өртөж байгаа ЕБС-ийн сурагчдад, өндөр настан, эмэгтэйчүүдийн хэрэгцээнд тулгуурлан төрөл бүрийн сургалтыг зохион байгуулах;
- Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд, хор уршгийн талаар олон нийтийн ойлголтыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах.
- Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг тууштай нэмэгдүүлэх;
- Сургуулийн өмнөх боловсролд хамрагддаггүй хүнд нөхцөлд амьдарч буй сургуулийн өмнөх насны хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үндсэн сургалтанд хамруулах;
- Бага насны хүүхдийн хөгжлийн хэрэгцээг хангах чанартай үйлчилгээ үзүүлэх;
- Малчдын хүүхдийг сургуульд бэлтгэх оновчтой хэлбэр болох явуулын багштай нүүдлийн болон гэр цэцэрлэг ажиллуулах;
- Сум бүрд сургуулийн өмнөх боловсролыг гэрийн нөхцөлд ойртуулах арга хэмжээ авч, хүүхдийн цэцэрлэгийн хамран сургалтыг нэмэгдүүлэх;

Гарах үр дүн: ЕБС, хүүхдийн цэцэрлэгийн хамран сургалтын хэмжээ нэмэгдэж, сургууль завсардалт арилж, хүн амын боловсролын түвшин дээшилсэн байна.

Стратегийн зорилт 2. Боловсролын байгууллагыг мэргэшсэн, чадварлаг хөрвөх чадвартай багш, удирдах ажилтнаар бүрэн хангаж, сургалтын орчин, үр дүнг дээшлүүлэх менежментийг боловсронгуй болгоно.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Багшийн хөгжлийг дэмжих замаар сургалтын чанарыг дээшлүүлэх;
- Сургалтад шинэ технологи, арга зүй нэвтрүүлэх замаар сургалтын стандартыг бүрэн хангаж, боловсролын хүртээмж, чанарыг сайжруулах;
- Сургууль, багш нарын ажлыг үнэлэх арга зүйг боловсронгуй болгох;
- Боловсролын байгууллагыг менежментийн хувьчлалд хамруулах;
- Кембрижийн боловсролын тогтолцоог нэвтрүүлэхтэй холбогдон багш нарын англи хэлний мэдлэгийг өндөр түвшинд хүргэх;
- “Багш бүрт компьютер” хөтөлбөр хэрэгжүүлэн багш бүрийг зөөврийн компьютертэй болгож, сургалтад мэдээллийн технологийн аргазүй нэвтрүүлэх;

Гарах үр дүн: Хөгжсөн багш нартай болж, ЕБС-ийн сургалтын чанар шинэ шатанд гарсан байна.

Стратегийн зорилт 3. Бүх шатны боловсролын сургуулийн материаллаг баазыг бэхжүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Бага сургууль, цэцэрлэгийн тоглоом, наадгай, сургалтын хэрэгсэл, материаллаг баазыг сайжруулах;
- Сургууль, цэцэрлэгүүдийн гал тогооны цахилгаан тоног төхөөрөмжийг иж бүрэн шинэчлэн, эрүүл ахуйн стандартад нийцүүлэх, үдийн цай хөтөлбөрийг хэрэгжүүлэх;
- Дотуур байрны болон цэцэрлэгийн хүүхдийн хоолны төрөл, амт, чанарыг сайжруулж, илчлэгийг стандартын хэмжээнд байлгах;
- Сургууль бүрийг хямд өртөгтэй, найдвартай ажиллагаа бүхий интернет номын сантай болгож, "Хүүхэд бүрд компьютер хөтөлбөр"-т бүх сумыг хамруулах
- Сургуулиудын дотуур байрны хүчин чадлыг нэмэгдүүлэх;
- Боловсролын салбарт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжин, гадаад орны мэргэжлийн төрөлжсөн байгууллагууд, хандивлагчдаас тусламж, дэмжлэг авах замаар боловсролын салбарын материаллаг баазыг бэхжүүлэх;
- Багш нарыг орон сууцны хөтөлбөрт хамруулах, орон нутгийн төсвөөс багш нарт зориулан орон сууц барихад хөрөнгө хуваарилах, хувиараа орон сууц барихыг дэмжин бага хүүтэй, урт хугацааны зээлд хамруулах;
- Сургууль, цэцэрлэгийн барилгад их засвар хийж, орчин үеийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулан сургалтын орчны стандартыг хангах;
- Хүүхдийн хөгжих эрхийг хангах зорилгоор хүүхдийн хөгжлийн дугуйлан хичээллүүлэхэд шаардагдах хөгжим, техник хэрэгслэл, материаллаг баазыг бий болгох;
- Хүүхэд залуучуудын усан бассейн байгууламжтай болох;
- Боловсролын байгууллагуудын зарим бололцоотой барилга, байгууламж, техник тоног төхөөрөмжийг зориулалтаар нь түрээслүүлэх, аж ахуйн нэгж байгууллагатай хоршиж ажиллуулах чиглэлийг дэмжих.

Гарах үр дүн: Бүх шатны боловсролын сургуульд сурч боловсрох, сургах ая таатай нөхцөл бүрдэж, сургалтын чанарыг сайжруулахад үзүүлэх нөлөө нь нэмэгдсэн байна.

Стратегийн зорилт 4. Соёл, урлагийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгож, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж, соёл урлагийн мэргэжлийн байгууллагын жишиг хэмжээнд нийцүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Аймгийн төвд соёл, спортын цогцолбор барих
- Сумын соёлын төвийн барилгыг барих, соёлын төвийг мэргэжлийн боловсон хүчнээр хангах;
- Залуучуудын соёл, амралтын хүрээлэн байгуулах;
- Номын сан, музей, соёл, спортын төвүүдийн материаллаг баазыг бэхжүүлэн үйлчилгээг өргөжүүлэн, хүн амд мэдээлэл хүргэх төв болгон ажиллуулах;

- Номын сангийн уламжлалт үйлчилгээг орчин үеийн нэмэлт үйлчилгээтэй хослуулан чанар, хүртээмжийг сайжруулах;
- Номын сангийн үйлчилгээнд орчин үеийн техник технологи, дэвшилтэт арга хэлбэрийг нэвтрүүлэх, автоматжуулах, номын сангийн фонд, мэдээллийн баазыг өргөжүүлэх;
- Номын сангийн ширээ сандал, номын тавиур болон үзэсгэлэнгийн тавиур, хамгаалалтын соронзон хаалга, компьютерын тоог нэмэгдүүлснээр уншигчдын тоог өсгөх;
- Боржигин судлалын төвтэй хамтран Боржигин түмний түүх соёлын дурсгалт зүйлийг олж цуглуулах, музейн сан хөмрөгийг баяжуулах, түүний хадгалалт хамгаалалтыг сайжруулах, улмаар түүх соёл, дурсгалт зүйлс, утга соёлын өвийн бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх;
- Судалгаа шинжилгээний ажлын үр дүн болон иргэдийн гар дээр хадгалагдаж байгаа үзмэрийг худалдан авах замаар үзмэрээ баяжуулах;
- Түүх соёлын дурсгалт газруудыг сэргээн засварлах;
- Аймгийн соёл урлагийн байгууллагуудын менежментийг шинэчилж мэргэжлийн өндөр ур чадвартай боловсон хүчнээр бүрэн хангах;
- Оюуны сэтгэлгээний хөгжилд түлхэц өгөхүйц, уран сайхны өндөр түвшинд бүтээсэн урлагийн бүтээлийг дэмжих;
- Мэргэжлийн урлагийн байгууллагын урын санг баяжуулж, тэдгээрийн бүтэц, зохион байгуулалтыг оновчтой тогтоож, ажиллагсдын нийгмийн баталгаа, ажиллаж амьдрах нөхцлийг дээшлүүлэх;
- Боржигин бүс нутгийн утга соёлын уламжлалт урлагийн өв сан, түүх заншлыг судлан бүтээлчээр суралцах, улмаар орчин цагийн сонгомол бүтээлтэй хослуулах замаар "Боржигин чуулга"-ын уран бүтээлийн чанар, уран бүтээлчдийн ур чадварыг дээшлүүлэх;
- Иргэд, хүүхэд залуучуудыг соёлжуулах, тэдгээрийн харилцааны соёлыг сайжруулах ажлыг төрөл бүрийн хэлбэрээр зохион байгуулах;
- Хүүхдийн хөгжих эрхийг хангах орчин бүрдүүлэх;
- Хүүхэд багачуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хүүхэд багачуудын хөгжил оролцоог хангах чиглэлээр "Хүүхдийн ордон"-той болох;
- Хүүхдийн авьяас чадварыг хөгжүүлэх төрөл бүрийн уралдаан тэмцээнийг зохион байгуулах;
- Соёл урлагаар дамжуулан хүүхдэд гоо зүй, ёс суртахууны хүмүүжил олгох ажлыг эрчимжүүлэх;
- Хүүхдийн төлөвшил, хүмүүжилд эцэг эх, асран хамгаалагчдын үүргийг дээшлүүлэх зорилгоор "Эцэг эхийн сурган хүмүүжүүлэх боловсрол" зайны сургалтын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх;
- Уламжлалт зан заншил"-ын танхим байгуулж, ахмад настнуудаар дамжуулан хүүхэд, залуучуудын ёс суртахуун хүмүүжилд нөлөөлөх "Ахмадын загвар бүлэг" ажиллуулах;
- Иргэд олон нийтэд хүүхдийн эрхийн талаарх мэдлэг олгох ажлыг өргөжүүлэх;
- Орон нутагт хүүхдийг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр ОУБ, ТББ-ын хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрийн судалгаа гаргаж, нэгдсэн бодлогоор уялдуулж, хамтран ажиллах.

Гарах үр дүн: Соёл урлагийн байгууллагын материалаг бааз бэхжиж, хүн амд үзүүлэх соёл урлагийн үйлчилгээний нэр төрөл, хүртээмж, чанар дээшилж, хүүхэд залуучууд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх нөхцөл бүрдсэн байна.

Хоёрдугаар үе шат (2016-2021 он):

Стратегийн зорилт 1. Аймгийн боловсролын байгууллагын тогтолцоо, сургалтын хэв шинжийг олон улсын нийтлэг жишигт хүргэнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Бүх нийтэд боловсрол эзэмшүүлэх Мянганы хөгжлийн зорилтыг бүрэн хэрэгжүүлэх;
- Ерөнхий боловсролын сургуулийн багш нарыг хөрвөх чадвартай болгон хөгжүүлэх;
- Сургууль завсардалт болон бичиг үсэг үл мэдэх явдлыг бүрэн арилгах;
- Хувийн хэвшлийн сургууль байгуулахыг дэмжих;
- Бүх сургууль, цэцэрлэгийг мэдээллийн технологийн техник хэрэгслээр хангах ажлыг зохион багуулж, тэдгээрийг интернетэд холбон, сургалтад мэдээллийн технологийг бүрэн нэвтрүүлэх,
- Багш, боловсролын байгууллагын удирдах ажилтны мэдлэг чадвар, манлайлах үр чадварыг хөгжүүлж, нийгмийн хамгааллыг сайжруулах;
- Мэргэжлийн сургалттай ахлах сургууль байгуулж, бүрэн дунд боловсрол эзэмшигчдэд мэргэжлийн боловсрол давхар эзэмшүүлэх;
- Уул уурхай, биотехнологи, мэдээллийн технологийн чиглэлээр авъяастай залуучуудыг сонгон шалгаруулж, өндөр хөгжилтэй орнуудад сургах.

Гарах үр дүн: Аймгийн боловсролын байгууллагын олон улсын жишигт нийцсэн тогтолцоо, хэв шинж бүрдэж сургалтын чанар эрс сайжирсан байна.

Стратегийн зорилт 2. Соёл урлагийн байгууллагуудын бие даан ажиллах оновчтой тогтолцоо бүрдүүлэн, үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Ардын авьяастан, уран бүтээлч, урчуудыг тодруулж дэмжих;
- Номын сан, архивын үйлчилгээг хүн амын эрэлт хэрэгцээнд нийцүүлэн сайжруулах, электронжуулж интернетэд холбох ;
- Номын санг сургалт, эрдэм шинжилгээний мэдээллийн төв болгон хөгжүүлэх;
- Номын сангийн нөхцөлийг MNS 5742 стандартын дагуу бүрэн хангах;
- Номын санчдын мэргэжил, нийгэм, улс төр, эрх зүй, эдийн засгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх;
- Музейг эрдэм шинжилгээ, судалгааны арга зүйн төв болгох зорилгоор музейн барилгыг шинээр барих, музейн тоног төхөөрөмж, дохиоллын системийг шинэчлэн, камерт холбох;
- Музейн үзмэрийн танхим болон фондын өрөөг стандартад нийцүүлэх;
- Зүүн Чойр хийдийн туурь, Зараагийн өврийн хүн чулуу, Дагвасүндэл бурханы урьд суврагыг сэргээн засварлах;
- Чойрын богд уулыг улсын хамгаалалтад оруулах.
- Сумын соёлын төвийн багшийн үр чадварыг дээшлүүлэх, иргэд олон түмэнд соёл олон түмний ажлыг нийгмийн шаардлагын хэмжээнд хүргэх.

Гарах үр дүн: Аймгийн соёл урлагийн байгууллагын бие дааж ажиллах чадавхи бий болж, үйлчилгээний хүртээмж чанар дээшилсэн байна.

3.4. Эрүүл мэндийн хөгжлийн бодлого

Үндэслэл. 2009 оны байдлаар тус аймагт гарч бүртгэгдсэн халдварт өвчин 149, амьд төрсөн хүүхдийн тоо 187, амьд төрсөн 1000 хүүхэд тутамд ногдох нялхсын эндэгдэл 20.8, үр хөндөлтийн тоо 23, 10000 хүн амд ногдох хорт хавдраар өвчлөлт 6.1, нас баралтын тоо 7.6, жирэмсэн эмэгтэйчүүдийн эмнэлгийн хяналтад хамрагдсан хувь жирэмсний эхний 3 сард 84.2 хувь, зургаа ба түүнээс дээш сард 97.5 хувьтай байна.

Аймгийн эрүүл мэндийн байгууллагуудын үзүүлж буй үйлчилгээ, эмчилгээ-оношлогооны чанар, тоног төхөөрөмжийн хангамж хүрэлцээ сайжирч байгаа хэдий ч санхүүгийн чадавхи хязгаарлагдмал, сум болон өрхийн эмнэлгийн үйлчилгээний чанар хүртээмж жигд бус байна.

Цаашид эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүн амд тэгш хүртээмжтэй, хүргэж, эндэгдлийг тууштай бууруулж, орчин үеийн дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэн эмчилгээ оношлогооны чанарыг сайжруулах шаардлагатай.

Нэгдүгээр үе шат (2010-2015 он):

Стратегийн зорилт 1. Хүн амын эрүүл мэндийг хамгаалах орчин үеийн тогтолцоог цогц байдлаар бүрдүүлэн иргэдийн эрүүл мэндийн үндсэн хэрэгцээг хангахад шаардагдах нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, хамралтыг сайжруулна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Аймгийн эрүүл мэндийн салбарын хөгжлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх;
- Бүс нутгийн хэмжээнд үйлчлэх оношлогоо, эмчилгээний төв бий болгох;
- Аймгийн хүн амын өвчлөлийн байдлыг тогтоох судалгаа явуулж, эрүүл мэндийн байдлыг хянан тандаж мэдээлэх тогтолцоо бүрдүүлэх;
- Аймгийн эрүүл мэндийн салбарын бүтэц тогтолцоог боловсронгуй болгож, улсын болон хувийн хэвшлийн эмнэлгийн оношлогоо, эмчилгээний чадавхийг сайжруулах;
- Хүрээлэн байгаа орчны бохирдол, эрсдэлт хүчин зүйлийг тооцох, хор хөнөөлийг нотолгоонд тулгуурлан үнэлэх орчны эрүүл зүйн лабораторийг бий болгох
- Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, эрүүл мэндийг дэмжих арга хэмжээ, эрүүл аймаг, сум, баг болох санал санаачилгыг хөхиүлэн дэмжиж, төрийн болон төрийн бус байгууллага, нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж байгууллага, хамт олон, иргэний нэгдмэл үйл ажиллагаагаар хэрэгжүүлэх
- Малчдад явуулын амбулаторийн үйлчилгээ үзүүлэх тогтолцоог бүрдүүлэх;
- Хүнсний болон эмийн аюулгүй байдлыг хангах стандартуудыг хэрэгжүүлэх;
- Уламжлалт анагаах ухааны үйлчилгээг дэмжих;
- Хүн амын эмзэг бүлгийг эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээнд бүрэн хамруулах;
- Залуу гэр бүлд нөхөн үржихүйн болон эрүүл мэндийг хамгаалахад нь бүх талын дэмжлэг үзүүлэх, залуу үеийнхэнд зонхилон тохиолдож байгаа халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэдгээрийн орчны таагүй нөлөөллийг багасгах, архи,

тамхи, мансууруулах бодисын дон, биеэ үнэлэх, сэтгэцийн хямралд өртөх зэрэг хорт зуршлаас өөрийгөө хамгаалах талаар мэдээлэл, зөвлөлгөө өгөх үйлчилгээг боловсронгуй болгох;

- Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажиллаж амьдрах, эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэхэд иргэд, аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг чиглүүлэх, тэдэнд зориулсан сэргээн засах үйлчилгээг хөгжүүлэх;
- Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд эмчилгээ, асаргаа, сувилгаа хийх, соёл ахуйн үйлчилгээ үзүүлэх тогтолцоог боловсронгуй болгох, тэднийг гэр бүл, ураг төрлийн хүрээ, орон нутагт нь асрамжлан халамжлах нөхцөл бүрдүүлэх.

Гарах үр дүн: Өмчийн олон хэлбэрт түшиглэсэн хүн амын эрүүл мэндийг хамгаалах цогц тогтолцоо бүрдэж, оношлогоо, эмчилгээний чадавхи сайжирч, үйлчилгээний хүртээмж, чанар дээшилсэн байна.

Стратегийн зорилт 2. Зонхилон тохиолдох өвчин эмгэгийг оношлох, эмчлэх нөхцөлийг бүрдүүлэх замаар хүн амын өвчлөл, эндэгдлийг бууруулна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Эх нялхсын эрүүл мэндэд онцгой анхаарч, "Мянганы хөгжлийн зорилт"-д нийцүүлэн эх нялхсын эндэгдлийг бууруулах;
- Эх, нялхсын эрүүл мэндийг хамгаалах үйлчилгээг хүртээмжтэй, чанартай болгох, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, мэдээлэл чөлөөтэй хүртэх бүх талын нөхцөлийг бүрдүүлэх;
- Эхийн эндэгдлийг бууруулах стратеги, нөхөн үржихүйн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх;
- Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эрэлт хэрэгцээг эмнэлгийн анхан шатны тусламжийн хүрээнд эх, нярайд шаардлагатай, чанартай эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж, хүртээмжийг сайжруулах;
- Нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйл ажиллагаанд эрэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлж тэдний мэдлэг, хандлага, дадлыг өөрчлөх;
- Уураг амин дэм, иод, төмрийн дутлаас сэргийлэхэд чиглэсэн цогц арга хэмжээ авах;
- Дархлаажуулалтын нэр төрлийг нэмэгдүүлж халдварт өвчнийг бууруулах
- Халдварт өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, бруцеллёз, сүрьеэгийн өвчлөлд тандалт судалгаа хийх;
- Олон улсын хөл хориот өвчнөөс урьдчилан сэргийлэх, хүн амын эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн оношлогоо эмчилгээний аргуудыг нэвтрүүлэх;
- Бэлгийн замаар дамжих халдвар, ХДХВ/ДОХ-оос сэргийлэх арга хэмжээний талаар дэлхийн эрүүл мэндийн байгууллага, олон улсын салбар хоорондын хамтын ажиллагааны төсөл, хөтөлбөрийг дэмжин хэрэгжүүлэх;
- "Халдварт өвчний тандалт сэргийлэлтийн алба"-ыг байгуулж, халдварт өвчнөөс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгсэл, вакцин, санхүү, хүний нөөцийг зохих түвшинд бүрдүүлэх, хамгаалах хувцас хэрэгслийн хангалтыг нэмэгдүүлэх;
- Зүрх судасны өвчин, хорт хавдар, осол гэмтлээс шалтгаалсан нас баралтаас урьдчилан сэргийлэх, хамгаалах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх;

- Хүүхдийг хөхөөр хооллох, хүүхдийн хоол тэжээл, иод дутлын эмгэгтэй тэмцэх, өсвөр үеийнхний эрүүл мэнд, дархлаажуулалт, хүүхдийн амьсгалын замын цочмог халдвар, суулгалт өвчинтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх;
- Эмч, мэргэжилтнүүдийн мэдлэг үр чадварыг дээшлүүлэх замаар хүүхдийн дунд зонхилон тохиолдож буй өвчний оношлогоо эмчилгээг сайжруулан хүүхдийн өвчлөлийг багасгаж, нялхсын болон хүүхдийн эндэгдлийг бууруулах;
- Бага насны хүүхдүүдийн шүд цоорох өвчлөлийг бууруулах, өсвөр үеийнхний амны хөндийн эрүүл мэндийг хамгаалах;

Гарах үр дүн: Хүн амын дотор зонхилон тохиолддог өвчний оношлогоо, эмчилгээний чанар дээшилж, эх нялхас болон хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, хүн амыг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үйлчилгээний хүтээмж, чанар сайжирч, хүн амын өвчлөл, эндэгдэл буурсан байна.

Стратегийн зорилт 3. Эрүүл мэндийн байгууллагын материаллаг бааз, хүний нөөцийн хангамжийг сайжруулах, санхүүгийн удирдлага болон даатгалын тогтолцоог шинэчлэн бэхжүүлж, хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах ажлын хүртээмжийг нэмэгдүүлэх .

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Эрүүл мэндийн салбарын хөгжлийн хандлагад нийцүүлэн аймгийн эрүүл мэндийн салбарын шинэчлэлийг эрчимжүүлэх;
- Эрүүл мэндийн байгууллагуудыг стандартад нийцсэн барилга байгууламжаар хангаж, материаллаг баазыг нь бэхжүүлэх, эмнэл зүйн стандарт, удирдамжийн хэрэгжилтийг хангах, хүний нөөцийн хуваарилалтыг судлан хянах замаар эрүүл мэндийн зардлын эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх;
- Эрүүл мэндийн салбарын санхүүгийн болон холбогдох нөөцийн ашиглалтын үр дүн, үр ашгийг сайжруулах зорилгоор санхүүгийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх;
- Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын хөрөнгө оруулалтыг дэмжих замаар эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг олон эх үүсвэртэй болгох;
- Боловсронгүй болгосон нийгмийн даатгалын тогтолцооны хэрэгжилтийг хангах;
- Эрүүл мэндийн даатгалын тогтолцоог шинэчлэн хөгжүүлэх, хэрэгжүүлэх;
- Аймгийн нэгдсэн эмнэлгийн орчин үеийн оношлогоо, эмчилгээний багаж хэрэгсэл, техник тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлж тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах;
- Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулж, мэс засал, шүд, хүүхэд, лаборатори, уламжлалт анагаах ухаан зэрэг зарим нарийн мэргэжлийн үйлчилгээг өргөтгөх;
- Амаржих газар, эхчүүдийн амрах байруудыг шинээр барих, өргөтгөх, тохижуулах;
- Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахын тулд түргэн тусламжийн унаа, холбооны хэрэгсэл, нэн тэргүүнд шаардлагатай чанартай эм, багаж хэрэгслэлээр хангах, сумдын эмнэлгийг компьютержүүлэн нэгдсэн сүлжээнд холбон, мэдээллийн чанар хүртээмжийг сайжруулах;
- Сумын эрүүл мэндийн төвөөр үзүүлэх хүн амын тоо, байршлаас хамааран багийн эмчийн салбарыг байгуулах
- Бохир усны сүлжээ, татуурга, цооног, бие засах газрын стандарт, эрүүл ахуйн шаардлагыг хангаж, цэвэрлэх байгууламжийн техник, технологийг сайжруулах;

- Ундны усны хатуулаг, төмөржилт, эрдэсжилт ихтэй сумын төв, хот, суурин газруудад ус зөөлрүүлэх төхөөрөмж суурилуулан хүн амын ундны усны чанарыг сайжруулан, хүн амыг стандарт, эрүүл ахуйн шаардлагад тохирсон ундны болон ахуйн усаар найдвартай хангах;
- Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн захиалгаар мэргэжлийн эмч бэлтгэх замаар эмнэлгийн мэргэжилтний тоог нэмэгдүүлж, тогтвор суурьшлыг нь сайжруулах;
- Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг бэхжүүлэх бодлогыг хэрэгжүүлж, хүний нөөцийн менежментийг боловсронгуй болгох;
- Өндөр мэдлэг, үр чадвартай эмч, сувилагч бэлтгэх, тэдний мэргэжлийг дээшлүүлж, орчин үеийн тоног төхөөрөмж эзэмшүүлэх.
- Хүүхдийн клиникийн төв байгуулах, нарийн мэргэжлийн оношлогоо, эмчилгээний орчин үеийн аппарат, хэрэгслээр хангах;
- Хүнд нөхцөлд амьдарч байгаа хүүхдүүдийг эрүүл мэндийн үзлэгт жигд хамруулах;
- Хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдүүдийг эмчийн үзлэгт хамруулах үйл ажиллагааг тогмолжуулах;
- Хүүхдийн нас бие сэтгэхүйн онцлогт тохирсон хүүхдийн сувилал байгуулах;
- Хөдөөгийн хүүхдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах тогтолцоо бүрдүүлэх;
- Өсвөр үеийн эрүүл мэндийг сахин хамгаалах асуудлаар санхүүгийн хөшүүрэг бий болгох;
- Хөгжлийн бэрхшээлтэй болон бага насны хүүхдийн оношлогоо, сувилгаа эрхэлдэг төрийн бус байгуулагуудад дэмжлэг үзүүлэх.

Гарах үр дүн: Хүн амын эрүүл мэндийг хамгаалах ээлтэй, аюулгүй орчин бүрдэж, эрүүл мэндийн санхүүгийн удирдлагын тогтолцоо бэхжиж, хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж сайжирсан байна.

Хоёрдугаар үе шат (2016-2021 он):

Стратегийн зорилт 1. Эрүүл мэндийн салбарын удирдлага, санхүүжилтийн нэгдмэл тогтолцоог бүрдүүлэн, материаллаг баазыг бэхжүүлж, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Мэдээллийн технологийн ололт амжилтыг эмнэлгийн тусламж үйлчилгээнд нэвтрүүлэх төсөл хэрэгжүүлэх;
- Сувилахуйн болон тусгай мэргэжлийн тусламж үйлчилгээний менежментийг боловсронгуй болгож тусгай мэргэжлийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх;
- Эрүүл мэндийг дэмжигч иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын үүсгэл санаачлагыг бүх талаар дэмжих, эрүүл мэндийн даатгалын байгууллагын тоог нэмэгдүүлэх;
- Гэр бүл төлөвлөх, эмэгтэйчүүдийн эсэн мэнд амаржих, өсвөр үеийг бэлгийн амьдралд бэлтгэх зэрэг нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний стандартыг хангах;
- “Эрүүл мэндийн салбарт хөгжүүлэх төр, хувийн хэвшлийн талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх үүднээс хувийн хэвшлийн эмнэлгийн байгууллагуудыг нэмэгдүүлэх;

- Аймгийн төвд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан нөхөн сэргээх, асрах сувилал байгуулах;
- Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээг өргөтгөж материалаг баазыг бэхжүүлэх;
- Хүн амыг зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслэлээр жигд, хүртээмжтэй тасралтгүй хангах;
- Нэгдсэн эмнэлэг болон сумдын эрүүл мэндийн төвийн байрыг өргөтгөх, засварлах, шинээр барих.

Гарах үр дүн: Өмчийн олон хэвшилд суурилсан аймгийн эрүүл мэндийн салбарын удирдлага, санхүүжилтийн нэгдмэл тогтолцоог бүрдэж, хүн амд үзүүлэх нийгмийн эрүүл мэндийн тусламж, сувилгааны хүртээмж, чанарын түвшин дээшилсэн байна.

Стратегийн зорилт 2. Аймгийн хүн амд эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэх, өсвөр залуу үеийг эрүүл чийрэг бие бялдартай өсгөж хүмүүжүүлэх, иргэдийн эрүүл мэндийг бэхжүүлэхийн тулд урьдчилан сэргийлэх талаар орчин үеийн дэвшилтэт арга ажиллагааг нэвтрүүлэн хүн амын эрүүл мэндийг сайжруулж, дундаж наслалтыг уртасгах.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Аймгийн төв болон сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд бие бялдрыг чийрэгжүүлэх, бялдаржуулах төв, өрөөг байгуулах;
- Хүн амд эрүүл аж төрөх ёсны мэдлэг олгож, эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэх;
- Халдварт өвчин болон бэлгийн замаар дамжих халдварыг бууруулах;
- Эхийн эндэгдлийг бууруулах стратеги, нөхөн үржихүйн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх;
- Сум, өрхийн эрүүл мэндийн төвөөр үзүүлэх асаргаа, сувилгааны нэр төрлийг нэмэгдүүлж хөдөөгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх.

Гарах үр дүн: Хүн амд үзүүлэх асаргаа сувилгааны хүртээмж, чанар сайжирч, эрүүл мэндээ хамгаалах сэтгэлзүйн ухамсар, сэтгэлгээ төлөвшсэн байна. Халдварт өвчний гаралт, эхийн эндэгдэл багассан байна.

ДӨРӨВ. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Говьсүмбэр аймгийн хөгжлийн 2-6 дахь тэргүүлэх чиглэлийн хүрээнд 2010-2015 онд мэдлэгт суурилсан эдийн засгийн үндэс суурийг тавьж, 2015 онд нэг хүнд ногдох ДНБ-ийг 6.7 сая төгрөгт хүргэж 2009 онтой харьцуулбал 2.6 дахин нэмэгдүүлнэ. 2021 онд нэг хүнд ногдох ДНБ-ийг 13.6 сая төгрөгт хүргэн 2009 онтой харьцуулбал ДНБ-ийг 5.2 дахин нэмэгдүүлж мэдлэгт суурилсан, өөрөө өөрийгөө тэтгэдэг эдийн засгийг бий болгосон байна.

4.1. Макро эдийн засгийн бодлого

Үндэслэл: Говьсүмбэр аймаг 2009 онд улсын ДНБ-ний 0.35 хувийг, Төвийн бүсийн 2.42 хувийг үйлдвэрлэжээ. 2009 онд 21 тэрбум 686.7 сая төгрөгийн ДНБ үйлдвэрлэсэнээс

хөдөө аж ахуйн салбарт 14.1 хувь, аж үйлдвэрийн салбарт 46.8 хувь, бусад салбарт 39.1 хувийг үйлдвэрлэжээ.

Тус аймгийн зээлийн өрийн үлдэгдэл 8 тэрбум 370.1 сая төгрөг, иргэдийн хадгаламжийн үлдэгдэл 1 тэрбум 897.6 сая төгрөг, чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 1 тэрбум 109.2 сая төгрөг байна.

Говьсүмбэр аймгийн орон нутгийн төсвийн орлого 2009 онд 1 тэрбум 597.2 сая төгрөг, орон нутгийн төсвийн зарлага 1 тэрбум 537.8 сая төгрөг, улсын төсвөөс орон нутагт олгосон санхүүгийн дэмжлэг 119.0 сая төгрөг байна.

Аймгийн дотоодын барилгын байгууллагууд гүйцэтгэсэн барилга байгууламж, их засварын ажил 737.1 сая төгрөг болжээ.

Ойрын жилүүдэд ашигт малтмал олборлох, малын гаралтай түүхий эдийг боловсруулж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хүнсний ногоо, мах, сүү, цагаан идээ боловсруулах, барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар аж үйлдвэр, барилгын салбарт өсөлт бий болгох боломжтой.

Нэгдүгээр үе шат (2010-2015 он):

Стратегийн зорилт 1. Энэ үе шатанд салбарын бүтцийг эрчимтэй шинэчлэн, аймгийн ДНБ-ий 7.9 хувийг ХАА-н салбарт, 30 хувийг аж үйлдвэрийн салбарт, 12 хувийг барилгын салбарт, 35.2 хувийг үйлчилгээний салбарт тус тус үйлдвэрлэнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Сумдыг эдийн засгийн чиглэлээр төрөлжүүлэн хөгжүүлэх, тухайлбал, **Баянтал суманд** мал аж ахуй, үйлдвэрлэл технологийн парк, **Шивээговь суманд** уул уурхайн үйлдвэрлэл, **Сүмбэр суманд** уул уурхайн боловсруулах болон барилгын материалын үйлдвэр, аймгийг мах, сүү, хүнсний ногоо, малын тэжээлээр хангахад чиглэгдсэн үйлдвэрүүд, бөөний худалдаа, нийтийн хоол, бүх төрлийн тээврийн болон бусад үйлчилгээ, аялал жуулчлал хөгжүүлэх;
- Мал аж ахуйн түүхий эд, газар тариалангийн бүтээгдэхүүнийг бүрэн боловсруулах үйлдвэрүүдийг байгуулж экспортын баримжаатай үйлдвэрлэлийн үндэс суурийг тавих;
- Ашигт малтмалын томоохон ордуудыг түшиглэн уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэрүүдийг байгуулж ажиллуулах;
- Түүхий эдийн нөөцөд тулгуурлан барилгын материалын үйлдвэр байгуулах;
- Бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлж, мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх;
- Аялал жуулчлалыг хөгжүүлж, эдийн засгийн өсөлтөд мэдэгдэхүйц нөлөө бүхий салбар болгох;
- Үйлдвэрлэл, үйлчилгээг өргөжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого барьж, зээлийн хүүг үе шаттайгаар бууруулах;
- "Говьсүмбэр аймгийн хөгжлийн банк" байгуулах;
- Аймгийн давуу тал, нөөцөд тулгуурласан эдийн засгийн шинэ салбар, өндөр технологид тулгуурласан шинэ үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгох;
- "Нэг суурин-Нэг бүтээгдэхүүн" хөдөлгөөнийг сум бүрт өрнүүлж, чанар сайтай, өрсөлдөх чадвар бүхий "Брэнд" бүтээгдэхүүн үйлдвэрлэж дотоод, гадаадын зах зээлд гаргах;
- Олон улсын баталгаат агуулахын аж ахуй хөгжүүлэх.

Гарах үр дүн: Аймгийн эдийн засгийн бүтэц шинэчлэгдэж, үйлдвэр, үйлчилгээний салбар түлхүү хөгжиж, эдийн засагт эзлэх хувийн жин нь нэмэгдсэн байна.

Стратегийн зорилт 2. Татварын бааз суурийг бэхжүүлж, татвар төлөгчдийн хүрээг өргөжүүлэх замаар орон нутгийн болон улсын төвлөрсөн төсвийн орлогыг жил бүр ханган биелүүлж, хөтөлбөрийн хугацаанд улсын төсвөөс татаасгүй, бие даасан аймаг байх нөхцөлийг хангана.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Татварын цахим тайлангийн системийг бүрэн нэвтрүүлж, татварын тайланг интернэтээр хүлээн авдаг болсон байна.
- Хөтөлбөрийн нийт хугацаанд аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлөгчдийн тоог 1000-д хүргэнэ.

Гарах үр дүн: Аймаг бие даан хөгжих нөхцөл бүрдэж, зардлаа орлогоороо бүрдүүлж, аймгийн ДНБ-д төсвийн зарлагын эзлэх хувь буурсан байна.

Хоёрдугаар үе шат (2016-2021 он):

Стратегийн зорилт 1. Энэ үе шатанд аймгийн ДНБ-ий 5.1 хувийг ХАА-н салбарт, 34.4 хувийг аж үйлдвэр салбарт, 7.0 хувийг барилгын салбарт, 35.2 хувийг үйлчилгээний салбарт тус тус үйлдвэрлэнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Өндөр технологид тулгуурласан хөдөө аж ахуйн экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэл хөгжүүлэх;
- Уул уурхайн салбарт өндөр технологийн боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх;
- Аялал жуулчлалыг аймгийн эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болгох;
- Экспортын баримжаатай, хувийн хэвшилд тулгуурласан үйлдвэрлэл, үйлчилгээний салбарыг түлхүү хөгжүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг хангах;
- Боловсруулах аж үйлдвэр, уул уурхайн үйлдвэрлэл давамгайлсан, эрчимжсэн хөдөө аж ахуй бүхий аялал жуулчлал, үйлчилгээний салбар хөгжсөн аймгийн эдийн засгийн зохистой бүтэц бий болгох;
- Нутгийн өөрөө удирдах байгууллагын эдийн засгийн зохицуулалтын эрх мэдлийг өргөтгөхөд анхаарч, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх.

Гарах үр дүн: Аж үйлдвэр, үйлчилгээний салбар эрчимтэй хөгжиж, аймгийн эдийн засагт тэргүүлэх байр суурьтай болсон байна.

4.2. Эдийн засгийн бодит салбаруудын хөгжлийн бодлого

4.2.1. Аж үйлдвэрийн хөгжлийн бодлого

Үндэслэл: 2009 онд Говьсүмбэр аймгийн аж үйлдвэрийн салбар 16 тэрбум 568.9 сая төгрөгийн ДНБ үйлдвэрлэжээ.

Аймгийн нутаг дэвсгэрт Шивээ-Овоогийн нүүрсний ил уурхай, Геологи хайгуулын “Говь гео” хувьцаат компани, цахилгаан шугам сүлжээний дэд станц, нефть бааз зэрэг томоохон аж ахуйн байгууллага үйл ажиллагаа явуулж байна.

Говьсүмбэр аймагт Шивээ-Овоогийн нүүрсний уурхайг түшиглэн нүүрс химийн үйлдвэрийг байгуулж керолин, кокс, шингэн болон бусад бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн экспортлох, барилгын үйлдвэрлэл явуулах, Говьсүмбэр, Дундговь аймгийн нутгийг дамжин орших Хараатын ураны хүдрийг ашиглах, олборлох боломжтой.

4.2.1.1. Боловсруулах аж үйлдвэрийн хөгжлийн бодлого

Нэгдүгээр үе шат (2010-2015 он):

Стратегийн зорилт 1. Боловсруулах аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийг энэ үе шатанд жилд дунджаар 12.0 хувиар өсгөж, аж үйлдвэрийн салбарт эзлэх хувийн жинг нэмэгдүүлэх үндэс суурийн эхлэлийг тавьж, боловсруулах үйлдвэрүүдийг “Алтанговь” үйлдвэрлэл технологийн паркийн хүрээнд хөгжүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Аж үйлдвэрийг тэргүүлэх салбар болгон хөгжүүлж, эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэн аймгийн эдийн засгийн өсөлтийг тогтворжуулах;
- Нүүрс-химийн үйлдвэрийн цогцолбор байгуулах;
- Нүүрс болон биомассын түүхий эдээс хийн түлш (ДМЕ) гарган авах үйлдвэр байгуулах;
- Хөрс сайжруулах Бионүүрс (Char coal)-ний үйлдвэр байгуулах;
- Барилгын материалын керамик гулдмайн өндөр технологийн үйлдвэр байгуулах;
- Сэргээгдэх эрчим хүчний гибрид системийн угсрах үйлдвэр байгуулах;
- Өндөр технологийн Шилэн дарлагын аж ахуй ба Агро-ойн систем байгуулах;
- Нүүрснээс малын өвчин анагаах керолин, кокс химийн болон бусад бүтээгдэхүүн гарган авч дотоодын зах зээлд нийлүүлэх, улмаар экспортлох;
- Эдийн засгийн чөлөөт бүс, үйлдвэр технологийн парк байгуулах;
- Бөөний худалдааны сүлжээ байгуулах;
- Хүн амын өсөлттэй уялдуулан хүнсний хангамж, үйлдвэрлэлийг сайжруулах.
- Дундговийн Баянжаргалан, Говь-Угтаал сумын нутагт байгаа төмрийн хүдрийг түшиглэн, төмөрлөгийн болон нүүрс жоншны боловсруулах үйлдвэрийг байгуулах.

Гарах үр дүн: Аймгийн эдийн засагт боловсруулах аж үйлдвэрийн эзлэх хувийн жин нэмэгдэх үндэс суурийн эхлэл тавигдаж, эдийн засгийн чадавхи нэмэгдэнэ.

Стратегийн зорилт 2. Жижиг, дунд үйлдвэрлэл (ЖДҮ)-ийн хөгжлийг дэмжиж, өргөтгөн хөгжүүлэх таатай орчин бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Аймгийн эрчим хүч, тээврийн үйлчилгээ, суурьшил, хүний нөөцөд тулгуурлан орчин үеийн жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх;

- Бөөний худалдааны сүлжээнд түшиглэн мах, ноос ноолуур, арьс ширийг стандартын дагуу бэлтгэх, тэдгээрийг дотоодын үйлдвэрүүдтэй хоршин боловсруулах чиглэлийн ЖДҮ байгуулах;
- Хүн амын өсөн нэмэгдэж байгаа хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг хангах зорилгоор мах, сүү, төмс, хүнсний ногоо боловсруулах хүнсний жижиг, дунд үйлдвэрүүдийг байгуулах;
- Үйлдвэрлэл үйлчилгээний болон ахуйн хог, хаягдлыг ялгах, дахин боловсруулах бага оврын үйлдвэр байгуулах;
- Хэвлэх үйлдвэр байгуулах;
- Улсын ба орон нутгийн захиалгаар бараа, үйлчилгээ худалдаж авахад жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг оролцуулах;
- Жижиг, дунд үйлдвэрлэл хөгжих бааз суурийг өрхийн аж ахуй эрхлэх замаар бий болгох;
- Жижиг, дунд үйлдвэрлэгчдийг шаардлагатай мэдээллээр хангах ажлыг тогтмолжуулах, техник, технологийн сонголт хийхэд туслах, төсөл боловсруулахад зөвлөгөө өгөх, үйлчилгээ үзүүлэх төв байгуулах.

Гарах үр дүн: Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх таатай орчин бүрдэж, ажлын байр нэмэгдэж, ЖДҮ эрхлэгчдийн тоо өсөж, татварын бааз суурь өргөжсөн байна.

Стратегийн зорилт 3. Аймгийн эрдэс, түүхий эдийн нөөц, баялгийг эдийн засгийн эргэлтэд оруулж, уул уурхайн салбарын хувь нэмрийг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Шивээ-Овоогийн нүүрсний уурхайд геологийн бүрэн хайгуул, судалгаа явуулах, техник-технологийн шинэчлэл хийх;
- Эрдсийн түүхий эдийн нөөцийг ашиглан зам, барилгын материал, барилгын шил, дулаалгын материал, бал чулуу, эрдэс будаг, ханын материалын үйлдвэр байгуулах.

Гарах үр дүн: Аймгийн эдийн засагт уул уурхайн салбарын оруулах хувь нэмэр өссөн байна.

Хоёрдугаар үе шат (2016-2021он):

Стратегийн зорилт 1. Боловсруулах салбарын үйлдвэрлэлийг энэ үе шатанд жилд дунджаар 6.9 хувиар өсгөж, “Алтанговь” үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд боловруулах үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Бөөний худалдааны төвүүдийн үйл ажиллагааг олон улсын стандартын шаардлага хангасан түвшинд хүргэх;
- Нүүрс карбонжуулах (хагас кокс, миниметаллург) үйлдвэрлэл хөгжүүлэх;
- Кокс химийн (нүүрс баяжуулах, нүүрс хийжүүлэн шингэрүүлэх, азот, аммиак, азотын хүчил, азотын бордоо) үйлдвэрлэл хөгжүүлэх;

- Барилгын материал (цемент, тоосго, хавтанцар)-ын үйлдвэр байгуулах;
- Төмөр боловсруулах (төмөр хайлуулах, ган хийц-арматурын) үйлдвэр байгуулах;
- Зэс боловсруулах (хар зэс, катодын зэс, моторын утас, фосфоритын бордоо) үйлдвэр байгуулах;
- Циолитын (орон нутгийн түүхий эдэд түшиглэсэн нано техногийн үйлдвэр, эрчим хүчний хэмнэлттэй халаалт, хөргөлтийн тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл, циолитын уурхай) үйлдвэр байгуулах;
- Мод үржүүлгийн (хурдан ургадаг Мегафлора мод нутагшуулах, говийн унаган ургамлын нэг хайлас модны суулгац бэлтгэх аж ахуй байгуулах);
- Сургалт-үйлдвэрлэл-судалгаа (Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, Чойрын технологийн их сургууль, Химийн аж үйлдвэрийн эрдэм шинжилгээний үндэсний хүрээлэн)-ны төв байгуулах;
- Уламжлалт бус эрчим хүчний тоног төхөөрөмж (цөмийн эрчим хүч, нар салхины эрчим хүчний)-ийн үйлдвэрлэл хөгжүүлэх;
- Хөнгөн (нэхмэл, оёдлын) үйлдвэр байгуулах;
- Аймгийн төвд техникийн эсгийний үйлдвэр байгуулах.
- Төмөр зам болон авто замын тээвэр, агуулах, гаалийн баталгаат агуулах бүхий тээвэр зуучлалын терминал хөгжүүлэх.

Гарах үр дүн: Аймгийн аж үйлдвэрийн салбарт боловсруулах аж үйлдвэрийн эзлэх хувийн жин тууштай нэмэгдсэн байна.

4.2.1.2. Геологи, уул уурхай, эрдэс баялаг, хүнд үйлдвэрийн хөгжлийн бодлого

Нэгдүгээр үе шат (2010-2015 он):

Стратегийн зорилт 1. Геологи, уул уурхай, эрдэс баялаг, хүнд үйлдвэрийн салбарын ДНБ-ийг энэ үе шатанд жилд дунджаар 42.1 хувиар өсгөж, экспортын баримжаатай үйлдвэрлэлийн үндэс суурийг тавина.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Ашигт малтмалын ордуудыг ашиглалтад оруулахад шаардлагатай дэд бүтэц бүрдүүлэх;
- Шивээ-Овоогийн нүүрсний уурхайг төслийн хүчин чадалд хүргэх олон улсын төсөл бэлтгэж, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татах;
- Уул уурхайн болон техникийн мэргэжилтэнг орон нутагт бэлтгэх боломжийг судлан хэрэгжүүлэх.
- Чойр Нялгын сав газар дахь нүүрс, битумын орд газруудыг ашиглаж эхлэх

Гарах үр дүн: Уул уурхайн үйлдвэрлэлийг хурдацтай өсгөх суурь нөхцөл бүрдэж, экспортын баримжаатай үйлдвэрлэлийн үндэс суурийг тавьсан байна.

Стратегийн зорилт 2. Уул уурхайн салбарт байгаль орчныг хамгаалах, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах бодлого баримтлана.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Уул, уурхайн ашиглалтад өртсөн талбайн нөхөн сэргээлтийг сайжруулах;

- Уурхайн олборлолтын технологид нэгдсэн стандарт мөрдүүлэх;
- Уурхайн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах, ашигт малтмалыг далд аргаар олборлох, газрын гүнд боловсруулалт хийхийг дэмжих;
- Уур амьсгалын өөрчлөлт, уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас шалтгаалан гадаргын болон газрын доорх усны экосистем доройтох, бэлчээр хомсдох зэрэг сөрөг нөлөөллийг багасгах.

Гарах үр дүн: Уул уурхайн олборлолт явагдсан газрын экологийн тэнцвэрт байдал хадгалагдсан байна.

Хоёрдугаар үе шат (2016-2021 он):

Стратегийн зорилт 1. Геологи, уул уурхай, эрдэс баялаг, хүнд үйлдвэрийн салбарын ДНБ-ийг энэ үе шатанд жилд дунджаар 19.3 хувиар өсгөнө.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Эрдэс, түүхий эдийн нөөцийг иж бүрэн ашиглах, хаягдалгүй, байгаль орчинд халгүй, өндөр технологи нэвтрүүлэх;
- Эрдэс түүхий эдийн олборлолтыг хүчин чадлын нь хэмжээнд байлгаж, боловсруулалтын түвшинг ахиулж, эцсийн бүтээгдэхүүний гаргалтыг нэмэгдүүлэх;
- Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн цогцолборыг дагасан жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх;
- Уул уурхайн болон барилгын үйлдвэрлэлийн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх.

Гарах үр дүн: Уул уурхайн олборлолт, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт нэмэгдсэн байна.

4.2.2. Хөдөө аж ахуйн хөгжлийн бодлого

Үндэслэл: Говьсүмбэр аймгийн хөдөө аж ахуйн салбар 2009 онд 3 тэрбум 57.8 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэжээ.

2009 онд Говьсүмбэр аймагт 168.7 мянган толгой мал тоологдсоноос адуу 6.9 мянга, хонь 69.7 мянга, тэмээ 0.5 мянга, үхэр 3.4 мянга, ямаа 88.2 мянга байгаа бөгөөд үүнээс, нийт хээлтэгч мал 79.1 мянга, хээлтүүлэгч мал 1.6 мянга, хээл хаясан хээлтэгчийн тоо 2443, сувайрсан хээлтэгчийн тоо 5210, гарсан төл 63060, бойжсон төл 57088, хорогдсон төл 5972, худалдсан, шилжүүлсэн төл 4767, том малын зүй бус хорогдол 6838, зах зээлд борлуулсан мал 19527, аж ахуй, дотоодод хэрэглэсэн мал 17396, байна.

Нийт малын 93.2 хувийг бог мал, 6.8 хувийг бод мал эзэлж байна. Нийт сүрэгт таван төрлийн малын хувийн жинг авч үзвэл тэмээ 0.3 хувь, адуу 4.1 хувь, үхэр 2.0 хувь, хонь 41.3 хувь, ямаа 52.3 хувийг тус тус эзэлж байна.

Тус аймаг нийт 495 малчин өрхтэй, 788 малчидтай. Малчин өрхийн зарим үзүүлэлтүүдийг авч үзвэл, цахилгаан үүсгүүртэй 389, телевизортой 338, авто машинтай 129, мотоциклтэй 289, трактортай 12 өрх байна.

Говьсүмбэр аймаг 2009 онд 47.3 га газар тариалалт хийснээс 18.5 га–д төмс, 5.8 га–д хүнсний ногоо, 23.1 га–д тэжээлийн ургамал тариалж, төмс 96.9 тн, хүнсний ногоо 22.3 тн, тэжээлийн ургамал 0.8 тн, байгалийн хадлан 0.7 мянган тн хураан авчээ. Нэг га-гаас хураан авсан төмс 52.4 тн, хүнсний ногоо 2.6 тн, тэжээлийн ургамал 6.1 тн байна.

Тус аймгийн мал аж ахуйн салбарт сүү, махны чиглэлийн үхэр; сүү, ноолуур, махны чиглэлийн ямаа; ширүүвтэр ноост хонь, гахай, шувууны аж ахуй зэрэг эрчимжсэн фермерийн аж ахуйг хөгжүүлэх боломжтой. Цаашид бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлийг хослуулан хөгжүүлэх, нутгийн малын чанарыг сайжруулах, каракулын "Сүмбэр" үүлдрийн хонины удмын санг хамгаалан тоо толгойг нэмэгдүүлэх; хөрсний үржил шимийг хамгаалах, байгаль орчинд халгүй технологиор газар тариалан эрхлэх; нэг мал, нэгж талбайгаас авах ашиг шимийг нэмэгдүүлж хүн амын махны хэрэгцээг бүрэн хангаж байгааг баталгаажуулж, төмс, хүнсний ногооны хэрэгцээг бүрэн, сүүний хэрэгцээний 50 хувийг үйлдвэрлэх зэргээр ХАА-н гаралтай хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх шаардлагатай.

Нэгдүгээр үе шат (2010-2015 он):

Стратегийн зорилт 1. Бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлж, малын үүлдэрлэг чанарыг сайжруулж, ХАА-н салбарын үйлдвэрлэлийг энэ үе шатанд жилд дунджаар 7.6 хувиар өсгөх, ХАА салбарын ДНБ-д эзлэх хувь хэмжээг 7.9 болгоно.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Аймгийн хөдөө аж ахуй хөгжлийг эрчимжүүлэх дунд хугацааны болон сүргийн зохистой бүтцийг бүрдүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;
- Малын удмын санг хамгаалах, үржлийн бодлогыг шинэчлэн сайжруулж, үржлийн малыг ээмэглэн цахим бүртгэлд оруулж, мэдээллийн сан бүрдүүлэх;
- Малын халдварт, паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг чанартай, мэргэжлийн өндөр түвшинд хийж малаас хүнд халдварладаг ям, сүрьеэ, бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, өрх, суурийн түвшинд эрүүлжүүлэх, хүн малын гоц халдварт өвчний үед хэрэглэх техник хэрэгслээр хангах
- Мал эмнэлгийн ариун цэврийн болон оношлох лабораторийг орчин үеийн техник хэрэгслэлээр хангаж, мэргэжилтнийг чадавхижуулахад гадаад, дотоодын зээл, тусламж, хөрөнгө оруулалтыг ашиглах;
- Өндөр ашиг шимт үүлдрийн мал сүргийн эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлж, ашиг шимт малыг өсгөх биотехнологийн аргыг нэвтрүүлэх;
- Мал эмнэлэг, үржлийн алба, үржлийн үйлчилгээний нэгжийн бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгож, материалаг баазыг бэхжүүлэн мэргэжлийн чадварлаг боловсон хүчнээр хангах;
- Малчдыг мэргэжлийн түвшинд сургаж бэлтгэн хөгжүүлэх, мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөтлөн явуулахад шинжлэх ухааны ололтыг нэвтрүүлэх;
- "Сүмбэр" хонины "Цөм сүргийн үржлийн төв"-ийг өргөжүүлж, нутгийн хонийг "Баянцагаан, Барга, Үзэмчин", ямааг "Баяндэлгэр", ноолуур, сүүний чиглэлийн "Дөрвөлжингийн буурал" зэрэг шилмэл омгоор сайжруулах;
- Өвөлжөө, хаваржааны бэлчээрийг худаг, уст цэгийн хамт малчдын бүлгүүдэд урт хугацааны гэрээгээр эзэмшүүлэх, аж ахуйн нэгж, малчид, иргэдийн хүчээр гүний худаг, гар худаг гаргах, хурын ус хуримтлуулах, булаг шандны усыг хамгаалах замаар бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх;
- Бэлчээрийг зохистой ашиглах, эзэмшүүлэх, хамгаалах, талхлагдсан бэлчээрийг нөхөн сэргээх замаар бэлчээрийн багтаамж, даацыг нэмэгдүүлэх;

- Бэлчээр хадлангийн талбайг хашиж хамгаалах, нөхөн сэргээх, малчдыг бүлгийн зохион байгуулалтад хамруулах ажлыг “Бэлчээрийн тогтвортой менежмент” төслийн байгууллагатай хамтран зохион байгуулах;
- Өрхийн аж ахуйг хоршсон хэлбэрт шилжүүлж, малын гаралтай түүхий эд боловсруулах жижиг, дунд үйлдвэр, хоршоо, фермерийн аж ахуйг хөгжүүлэх;
- “Сүмбэр” үүлдрийн хонины каракуль хурганы арьс болон бусад арьс нэхийнд анхан шатны боловсруулалт хийдэг жижиг үйлдвэр байгуулах;
- Каракуль хурганаас гарах ходоод, цүрд, нарийн гэдэс, мах, яс, цусыг ашиглах, боловсруулалт хийдэг жижиг үйлдвэр байгуулах,
- Сумдад мал нядалгааны болон мах боловсруулах хөргүүртэй нядалгааны цэг, зоорь байгуулах;
- Тэжээлийн ургамал тариалж малын нэмэгдэл тэжээлийн 30-аас доошгүй хувийг үйлдвэрлэх.

Гарах үр дүн:

- Мал эрүүлжиж, гоц халдварт өвчний гаралт, сөрөг нөлөөлөл эрс буурна
- Малын үүлдэрлэг чанар сайжирсан байна.
- Аймгийн хэмжээнд бэлчээрийн менежмент боловсронгуй болж, бэлчээрийн даац, ашиглалт үлэмж сјажирна
- Мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл өсч, малчдын ашиг орлого нэмэгдэнэ.

Стратегийн зорилт 2. Газар ашиглалтыг сайжруулж, усалгаатай тариаланг хөгжүүлэн, биотехнологи нэвтрүүлэх замаар газар тариалангийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Усалгаатай газар тариалан, мал аж ахуйг хослуулан хөгжүүлэх;
- Аймгийн хэмжээнд газар тариалангийн мэргэжилтэн-агрономич, механикжуулагч мэргэжилтнүүдийг бэлтгэх, давтан сургалтад хамруулах, сумдын захиалгыг харгалзан мэргэжилтэй ногоочид, тракторч-фермерийг бэлтгэх;
- Усалгаатай тариалан эрхлэх болон техникийн парк шинэчлэлийн бодлого боловсруулж, техник, технологийн шинэчлэл хийх;
- Өрхийн болон хүлэмжийн аж ахуйг хөгжүүлж, төмс хүнсний ногоо тариалах ажлыг эрчимжүүлэх, усалгаатай газар тариаланг хөгжүүлэх;
- Атаршсан талбайн судалгааг гаргаж, тариалалт хийх, төмс хүнсний ногоо, малын тэжээл үйлдвэрлэх зэргээр сэргээн ашиглах;
- Хөрс боловсруулах дэвшилтэт технологи, цомхотгосон болон тэг элдэншүүлгийг нэвтрүүлж эрдэс шим бордооны хэрэглээг өргөжүүлж, ойн зурвас байгуулах замаар хөрсний элэгдэл, эвдрэлийг багагах, үржил шимийг сайжруулах;
- Газар тариалангийн эрчимжсэн үлгэр жишээ загвар аж ахуйн нэгжийг сумдад байгуулах;
- Хүнсний бүтээгдэхүүнийг чанарын өндөр түвшинд найдвартай хадгалах агуулахын аж ахуйг хөгжүүлэх;
- Хүнсний нөөц бүрдүүлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, худалдаалах хүнсний бүтээгдэхүүний чанар аюулгүй байдлыг баталгаажуулах, хамгаалагдсан хөрсний таримлын хэмжээг нэмэгдүүлэх;

- Аюулгүйн нөөцийн зориулалт бүхий хүнсний гол нэрийн барааны орон нутгийн нөөцийн сан бүрдүүлэх, нөхөн сэлбэх;
- Хүн амын махны хэрэглээний бүтцэд гахай, тахианы махыг түлхүү оруулах, цөцгийн тосны хэрэглээг шар, цагаан тос, өрөм, цөцгий зэргээр орлуулах боломж бүрдүүлэх.

Гарах үр дүн: Газар тариалангийн үйлдвэрлэл тогтвортой өсч, хүн амын хүнсний бүтээгдэхүүний хангамж сайжирсан байна.

Хоёрдугаар үе шат (2016-2021он):

Стратегийн зорилт 1. Биотехнологийг тууштай нэвтрүүлж, малын үүлдэрлэг чанарыг сайжруулж, таримлын ургацыг нэмэгдүүлснээр ХАА-н салбарын үйлдвэрлэл энэ үе шатанд жилд дунджаар 5.2 хувиар өсөх ба уг салбарын ДНБ-д эзлэх хувийг 5.1 болж өөрчлөгдөнө.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Бэлчээрийн мал аж ахуйг эрчимжсэн мал аж ахуйтай хослуулан хөгжүүлж, экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх;
- Усалгаатай газар тариалангийн орчин үеийн технологийг өргөн нэвтрүүлж, 1 га-аас авах ургацыг нэмэгдүүлэх;
- Малын гаралтай түүхий эдэд анхан, дунд шатны боловсруулалт хийх;
- Хөдөөгийн малчин өрхүүдийн эрчим хүчний хангамжийг сайжруулах;
- Үржлийн сайн чанарын мал бойжуулан сүү, махны чиглэлийн үхэр үржүүлгийн аж ахуйн нэгжүүдийг өргөтгөх, сүү сүүн бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэр байгуулах;
- Өндөр ашиг шимт малын хээлтүүлэгч, түүний үр хөврөлийг үржилд өргөн ашиглах;

Гарах үр дүн: Малын үүлдэрлэг чанар сайжирч, таримал ургамлын ургац нэмэгдэж, ХАА –н үйлдвэрлэлийн өсөлт, түүний ДНБ-д эзлэх хувь стратегийн зорилтод дэвшүүлсэн хэмжээнд хүрсэн байна.

Стратегийн зорилт 2. Газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэн хөгжүүлснээр тариалан эрхлэгчид хөрөнгө, санхүүгийн хувьд бие даан өөрсдөө хөрөнгө оруулалт хийх боломжтой болно.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Сумдад усалгаатай тариаланг хөгжүүлж, сум бүрт 2-оос доошгүй газар тариалан, мал аж ахуй хоршсон эрчимжсэн хоршоо, ферм байгуулах;
- Ганд тэсвэртэй, богино хугацааны болцтой, ургац ихтэй үрийн сантай болох;
- Туслах аж ахуй эрхэлж байгаа өрхийг дэмжиж, өрхийн тоог нэмэгдүүлэх;

Гарах үр дүн: ХАА дахь хөдөлмөр зохион байгуулалт сайжирч, хоршоо, фермерийн загвар аж ахуй бий болно. Өрхийн амьжиргааны түвшин дээшилсэн байна.

4.2.3. Худалдаа, үйлчилгээний салбарын хөгжлийн бодлого

Худалдаа, үйлчилгээний салбар. Сүүлийн жилүүдэд худалдаа, үйлчилгээний салбар өргөжин хөгжиж байгаа хэдий ч үйлчилгээний чанар, хүртээмж шаардлагын

түвшинд хүрээгүй, бүтээгдэхүүний үнэ өндөр хэвээр байна. Энэ салбарт гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, ажиллах орчин нөхцөлийг сайжруулах шаардлагатай.

Нэгдүгээр үе шат (2010-2015 он):

Стратегийн зорилт 1. Аймгийн худалдаа, үйлчилгээний салбарын үйлдвэрлэлийг энэ үе шатанд жилд дунджаар 12.8 хувиар өсгөж, аймгийн ДНБ-д эзлэх хувийг 35.2 болгож, тус салбарын чанар, хүртээмжийг сайжруулна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Аймаг, сумын төвд худалдаа, үйлчилгээний цогцолбор төв байгуулахыг бодлогоор дэмжих;
- Бөөний болон жижиглэн худалдаа, зочид буудал, зоогийн газрын үйлчилгээнд тэргүүний техник, өндөр технологи нэвтрүүлэх;
- Худалдаа, үйлчилгээний салбарт интернет худалдаа, төлбөр тооцоог картаар хийх үйлчилгээ нэвтрүүлэх;
- Банк санхүү, үл хөдлөх хөрөнгө, түрээс зэрэг бизнесийн үйлчилгээний салбарт цахим үйлчилгээ нэвтрүүлэх;
- Худалдаа, үйлчилгээний ажилтнуудыг давтан сургах, мэргэшлийн түвшинг дээшлүүлж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах
- Худалдаа, үйлчилгээний газруудын үйл ажиллагаанд дотоодын болон иргэдийн зүгээс тавих хяналтыг сайжруулж, худалдаа, үйлчилгээний стандарт, норм, нормативыг мөрдүүлж хэвшүүлэх;
- Худалдаа, үйлчилгээний салбарт ажиллаж буй аж ахуйн нэгжүүдийг татвар, зээл, хөрөнгө оруулалтын оновчтой бодлогоор дэмжих;
- Чойр-Замын-Үүдийн босоо тэнхлэгийн авто зам баригдахтай холбогдуулж, зорчигчид, жуулчдад үйлчлэх техникийн үйлчилгээний цогцолбор төв бий болгох.

Гарах үр дүн: Худалдаа, үйлчилгээний үйлдвэрлэлийн салбарын чанар, хүртээмж сайжирч, түүний жилийн дундаж өсөлт болон аймгийн ДНБ-д эзлэх хувьхэмжээ стратеги зорилтод дэвшүүлсэн хэмжээнд хүрсэн байна.

Хоёрдугаар үе шат (2016-2021 он):

Стратегийн зорилт 1. Аймгийн худалдаа, үйлчилгээний салбарын үйлдвэрлэлийг энэ үе шатанд жилд дунджаар 7.2 хувиар өсгөж, 2021 онд аймгийн ДНБ-д эзлэх хувийг 25.2 болгож, аймгийн худалдаа, үйлчилгээний салбарын чанар, хүртээмжийг хөгжсөн орнуудын жишигт ойртуулна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Худалдаа, үйлчилгээний салбарт өндөр бүтээмжтэй техник, технологийг тууштай нэвтрүүлэх;
- Интернет худалдаа, цахим үйлчилгээг аймгийн иргэдийн өдөр тутмын хэрэгцээ болгож хэвшүүлэх;
- Иргэдийн хэрэгцээнд нийцүүлэн худалдаа, үйлчилгээний газруудыг хүчин чадал, үйлчилгээний нэр төрлөөр нь зохистой байршуулах.

Гарах үр дүн: Худалдаа, үйлчилгээний салбарын үйлдвэрлэлийн жилийн дундаж өсөлт болон түүний аймгийн ДНБ-д эзлэх хувь стратегийн зорилтод дэвшүүлсэн хэмжээнд хүрч, энэ салбарын чанар, хүртээмж олон улсын жишигт ойртсон байна.

4.2.4. Аялал жуулчлалын хөгжлийн бодлого

Үндэслэл. Говьсүмбэр аймгийн төв нь Хэрлэн голоос 90 км, Дорноговь аймгийн Халзан-Уулын рашаан сувиллаас 60 км зайд оршдог. Дотор эрхтний өвчнийг анагаах “Цоорхойн” рашаан, Аргаль, янгир нутагшсан Чойрын богд уул, эртний түүхт Зүүн Чойрын хийдийн туурь, Зараа хэмээх газарт байгаа эртний Түрэгийн хүн чулуун хөшөө дурсгалууд зэрэг байгалийн болон түүхийн дурсгалт газруудыг түшиглэн аялал жуулчлал хөгжүүлэх боломжтой.

Ойролцоо 4 аймгийн 10 орчим сумтай хиллэдэг, дээрх аймаг, сумдаас 65-200 км зайд оршдог, авто болон төмөр замын тээвэр тогтмолжсон хийгээд 2013 оноос Чойр-Замын үүдийн чиглэлийн босоо тэнхлэгийн авто зам ашиглалтад орох зэргээс үзэхэд дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх боломж бүхий аймаг юм..

Нэгдүгээр үе шат (2010-2015 он):

Стратегийн зорилт 1. Аялал жуулчлалын салбарыг эдийн засгийн биеэ даасан тэргүүлэх салбарын нэг болгоно.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Аялал жуулчлал хөгжүүлэх дэд хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх;
- Жуулчдад зориулан орон нутгийн онцлогийг харуулсан бэлэг дурсгалын зүйлс, үйлдвэрлэх, худалдаалах төв бий болгох;
- Аймгийн аялал, жуулчлалын лавлах, танилцуулга гарган, интернетэд ВЭБ хуудас нээн ажиллуулах;
- Аяллын тогтоосон маршрутын дагуух автозамыг засварлах, тэмдэгжүүлэх;

Гарах үр дүн: Дотоод, гадаадын жуулчид Говьсүмбэр аймгийн байгалийн болон түүхийн дурсгалт газруудын болон аймгийн тухай мэдээлэл олж авах нөхцөл бүрдсэн байна.

Стратегийн зорилт 2. Аялал жуулчлалын материаллаг баазыг бэхжүүлэн, менежментийг боловсронгуй болгоно.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Аялал жуулчлалын маршрутын дагуух байгалийн болон түүх, соёлын түүхийн дурсгалт газруудыг хамгаалах, сэргээн засварлах, аялал жуулчлал, үзмэрийн зориулалтаар бэлтгэх;
- Аймгийн орон нутгийн болон угсаатны зүйн музейг засварлах, музейн сан хөмрөгийг арвижуулах;

- Аялал жуулчлалын шинэ маршрут гарган дотоод гадаадын жуулчдыг хүлээн авах зочид буудал, жуулчны баазыг орчин үеийн шаардлага, стандартад нийцүүлэн байгуулах;
- Чөлөөт бүс байгуулахтай холбогдуулан дотоод, гадаадын жуулчдыг хүлээн авах зочид буудал, жуулчны баазыг бий болгох;
- Байгальд халгүй эрчим хүчний эх үүсвэрээр жуулчны баазуудыг хангах.

Гарах үр дүн: Дотоод, гадаадын жуулчдыг хүлээн авах, үйлчлэх тохилог, ая тухтай, аюулгүй орчин нөхцөл бүрдсэн байна.

Хоёрдугаар үе шат (2016 – 2021 он):

Стратегийн зорилт 1. Аялал жуулчлалын салбарын үйлчилгээний чанарыг олон улсын жишигт хүргэнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Аймгийн аялал жуулчлалыг олон улсын аялал жуулчлалын сүлжээнд хамруулах;
- Өвлийн аялал жуулчлалын цогцолбор бааз байгуулах;
- Аймаг, сумдад аялал жуулчлалын менежмент болон гадаад хэлний сургалтууд зохион явуулан аялал жуулчлалын салбарын ажилтнуудын боловсрол, сургалтын түвшинг олон улсын жишигт хүргэх.

Гарах үр дүн: Аялал жуулчлалын салбар түргэн хурдацтай хөгжиж, олон улсын жишигт хүрч, аймгийн эдийн засагт энэ салбарын эзлэх хувийн жин нэмэгдэнэ.

4.3. Дэд бүтцийн хөгжлийн бодлого

Үндэслэл. Говьсүмбэр аймагт эдийн засгийн дэд бүтэц харьцангуй сайн хөгжсөн, бизнесийн таатай орчин, амьжиргааны өртөг харьцангуй хямд зэрэгт түшиглэн, тус аймагт говийн бүсийн аймгуудын иргэдийн шилжилт суурьшилтын төв болох боломжтой.

Монгол улсын хойд хилээс өмнөд хил хүртэл тавигдсан шилэн кабелийн шугамд холбогдсон. Тоон АТС-ын системд шилжсэн, хөдөлгөөнт холбоо суурилагдсан. Дэлхийн аль ч улс оронтой телефоноор болон интернетээр харилцах боломжтой.

Налайх-Чойрын чиглэлийн 220 км хатуу хучилттай замтай, мөн Чойр-Сайншандын чиглэлд хатуу хучилттай зам тавигдаж байгаа.

Цахилгаан эрчим хүчний дамжуулах станц нь хүчин чадлынхаа 33 хувийг ашиглаж байгаа нь цахилгаан эрчим хүчний найдвартай эх үүсвэр, нөөцтэй гэдгийг харуулж байна. Бүх сумын төв эрчим хүчний байнгын, хүрэлцээтэй эх үүсвэртэй, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын жигд ажиллагааг хангах боломжтой. Гэвч цахилгаан, дулааны эрчим хүчний алдагдал ихтэй, хэрэглэгчдийн өрийн сүлжээ өргөжсөн.

Тус аймгийн нутгаар өнгөрч байгаа Сүхбаатар-Замын үүдийн төмөр замын тээх, нэвтрүүлэх хоногийн чадвар нь Улаанбаатар-Чойрын хооронд 16 хос, Чойр-Замын үүдийн хооронд 7 хос цуваа юм.

Тус аймаг дахь нефть хангамжийн бааз нь авто тээврийн хэрэгслээр шатахуун, тосолгооны материалыг говийн аймгуудад тээвэрлэн хүргэдэг.

Холбооны салбар нь олон суваг бүхий телевизийн релейний шугамтай, телефоны утсан холбооны 2-3 сувгаар үйлчилгээ үзүүлдэг.

Говьсүмбэр аймаг нь өнөөгийн байдлаар 3192 айлын орон сууц, 3 зочид буудал, 500 хүний суудалтай 3 клуб болон худалдаа соёл, ахуйн үйлчилгээний зориулалт бүхий олон барилга байгууламжтай.

4.3.1. Зам, тээврийн хөгжлийн бодлого

Бүх үе шат (2010-2021 он):

Стратегийн зорилт 1. Аймгийн авто замын болон агаарын тээврийг хөгжүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- “Мянганы зам”-ын босоо тэнхлэгийн авто замыг түшиглэн авто аж ахуй хөгжүүлснээр зорчигчид, жуулчдад үйлчлэх техникийн үйлчилгээний том хэмжээний төвийг байгуулах;
- Сумдын төвийг босоо тэнхлэгийн автозамтай хатуу хучилттай замаар холбох;
- Баянтал сумын нутаг дэвсгэр дэх нисэх онгоцны буудлыг сэргээн тохижуулж, олон улсын нислэг, реэкспорт, ложистикийн чиглэлээр ашиглах;
- Аймгийн төв, хотын дотор 10 км хатуу хучилттай авто болон явган хүний зам тавих, замын дагуу гэрэлтүүлэгтэй болгох.

Гарах үр дүн: Гадаад, дотоодын зорчигчид, жуулчдын тав тухтай, хурдан шуурхай, аюулгүй зорчих нөхцөл бүрдсэн байна.

4.3.2. Эрчим хүчний салбарын хөгжлийн бодлого

Нэгдүгээр үе шат (2010-2015 он):

Стратегийн зорилт 1. Эрчим хүчний салбарын үйлдвэрлэлийг энэ үе шатанд жилд дунджаар 1.5 хувиар өсгөж, уг салбарын аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлд эзлэх хувийн жинг 20.0 хувьд хүргэнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Эрчим хүчний эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэр бий болгох;
- Цахилгаан, дулааны зарцуулалтыг бүрэн тоолууржуулах;
- Аймаг, сумын төвийн дулааны зуухнуудад техник, технологийн шинэчлэлт хийх, өргөтгөх, дулааны шугамыг шинэчлэх, өргөтгөх;
- Сумын төвийн нэгдсэн халаалтын сүлжээнд айл өрхүүдийг холбох;
- Нүүрс, модыг орлох хий, шингэн түлшний эх үүсвэрийг ашиглах;
- “Буман нарны гэрэл” хөтөлбөрийг хэрэгжүүлэх;
- Эрчим хүчний салбарын хөдөлмөрийн нөхцөл сайжруулах асуудлыг бүрэн шийдвэрлэх;
- Аймгийн төвийн нэгдсэн дулааны станц, дулааны шугам сүлжээ байгуулах ажлын ТЭЗҮ боловсруулах,

Гарах үр дүн: Эрчим хүчний үйлдвэрлэлийн жилийн дундаж өсөлт, түүний аймгийн нийт үйлдвэрлэлд эзлэх хувийн жин стратегийн зорилтод дэвшүүлсэн хэмжээнд хүрсэн байна.

Хоёрдугаар үе шат (2016-2021 он):

Стратегийн зорилт 1. Эрчим хүчний салбарын үйлдвэрлэлийг энэ үе шатанд жилд дунджаар 1.4 хувиар өсгөж, уг салбарын аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлд эзлэх хувийн жинг 7.1 хувьд хүргэнэ. Энэ үе шатанд эрчим хүчний менежментийг боловсронгуй болгож, байгаль орчинд халгүй тэргүүний техник, технологи нэвтрүүлж, үйлдвэрлэл, хэрэглээний үр ашгийг дээшлүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Аймаг, сумын хуучирсан дулааны шугам сүлжээг шинэчлэх, өргөтгөх;
- Хөдөөгийн малчин айл өрхийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр бүрэн хангах;
- Барилга байгууламжид өргөнөөр ашиглагдаж байгаа нарны илчээр ус, агаар халаах арга, технологи, тоног төхөөрөмжийг хэрэглээний халуун ус болон бусад зориулалтаар өргөн ашиглах;
- Нүүрснээс утаагүй түлш үйлдвэрлэх бага оврын үйлдвэрүүд байгуулах.
- Аймгийн төвийн нэгдсэн дулааны станц, дулааны шугам сүлжээг барьж байгуулах

Гарах үр дүн: Эрчим хүчний үйлдвэрлэлийн жилийн дундаж өсөлт, уг салбарын аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлд эзлэх хувь хэмжээ стратегийн зорилтод дэвшүүлсэн хэмжээнд хүрч, үйлдвэрлэл, хэрэглээний хүртээж, чанар дээшилсэн байна.

4.3.3. Мэдээлэл, харилцаа холбооны салбарын хөгжлийн бодлого**Нэгдүгээр үе шат (2010 – 2021 он):**

Стратегийн зорилт 1. Мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтэц, сүлжээг шинэчлэх замаар “Мэдээлжсэн нийгэм”-ийг байгуулах үндэс суурийг тавина.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Аймаг, суманд “Цахим Монгол” хөтөлбөрийг хэрэгжүүлж, төрийн болон төсөвт албан газар, байгууллага, төрийн албан хаагч бүрийг дотоод сүлжээ, интернетэд бүрэн холбох;
- Хэвлэлийг электрон хэлбэрээр хүргэх;
- Аймгийн хэмжээнд бүх нийтийн компьютержүүлэлт, өрх бүрт интернет дэд хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх;
- Бүх сумын төвд интернет цэг, интернет кафе байгуулж, үйлчлэх;
- Бүх суманд кабелийн телевизийн нэвтрүүлэг үзэх нөхцөлийг бүрдүүлэх;
- Орон нутгийн телестудийг өргөжүүлэн, аймгийн нутаг дэвсгэрийг хамарсан мэргэжлийн телевизтэй болгох;
- Аймаг, сумын төвүүдэд мэдээлэл технологийн төв байгуулах;
- Хот суурингийн гудамж талбай, албан байгууллага, айл өрхийг хаягжуулж, шуудангийн бүсийн тогтолцоонд шилжүүлэх;
- Сумын төвийн холбооны систем болон аймаг, сумын хооронд дамжуулах системүүдийг тоон сүлжээнд бүрэн нэвтрүүлэх.

Гарах үр дүн: Мэдээлэл харилцаа холбооны орчин үеийн сүлжээний үндэс суурь тавигдсан байна.

Стратегийн зорилт 2. Мэдээлэл, харилцаа холбооны шинэ үйлчилгээ хэрэглээг төр, аж ахуйн болон үйлчилгээний бүхий л байгууллагад нэвтрүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Аймгийн төвийн төр, захиргаа, аж ахуйн нэгж байгууллагыг нэгдсэн сүлжээнд холбож, мэдээллийн сан бүрдүүлэх;
- Аймгийн төв, зарим сумдын төвийн эмнэлэг, сургуулийг мэдээлэл, харилцаа холбооны нэгдсэн сүлжээнд холбох;
- Мэдээллийн төрийн үйлчилгээг иргэдэд тэгш, хүртээмжтэй хүргэх;
- Электрон засаглал, электрон арилжаа, электрон үйлчилгээ, электрон гарын үсэг зэрэг шинэ төрлийн үйлчилгээг нэвтрүүлэх.

Гарах үр дүн: Аймгийн хэмжээнд мэдээлэл, харилцаа холбооны орчин үеийн үйлчилгээний төрөл нэвтэрсэн байна.

Стратегийн зорилт 3. Аймгийн хэмжээнд мэдээлэл, харилцаа холбооны мэргэжилтний чадавхийг дээшлүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Мэдээлэл, холбооны хэрэглээ, үйлчилгээг бага насны хүүхэд, өндөр настан, эмэгтэйчүүд болон нийгмийн эмзэг бүлэгт хүргэх сургалт явуулах;
- Аймгийн төвийн гэр хорооллуудад шилэн кабелийн цагирган сүлжээ бий болгож, айл өрх, албан байгууллагыг шилэн кабелиар интернэтэд холбогдох нөхцөлийг бүрдүүлэх
- Мэдээлэл, харилцаа холбооны технологийн өндөр үр чадвартай мэргэжлийн боловсон хүчин, инженер, техникийн ажилтнуудыг бэлтгэх, давтан сургах.

Гарах үр дүн: Аймгийн хэмжээнд мэдээлэл, харилцаа холбооны чадамж нэмэгдэж, үйлчилгээний хүртээмж, чанар нь дээшилсэн байна.

4.3.4. Хот байгуулалт, барилгын хөгжлийн бодлого

Тус аймагт ашиглалтгүй байгаа орон сууцны болон нийгмийн үйлчилгээ явуулах барилга байгууламжийг сэргээн засварлаж ашиглахад аж ахуйн нэгжийг оролцуулж, хувийн хөрөнгө оруулалтыг чиглүүлэх шаардлагатай.

Нэгдүгээр үе шат (2010-2021 он):

Стратегийн зорилт 1. Аймгийн төвийг батлагдсан ерөнхий төлөвлөгөөний дагуу эрчимтэй хөгжүүлнэ. Барилгын салбарын үйлдвэрлэлийн жилийн дундаж өсөлтийг 2010-2015 онд 12 хувиар, 2016-2021 онд 7.0 хувиар өсгөнө.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Аймаг болон 3 сумын хөгжлийн 2021 он хүртэлх ерөнхий төлөвлөгөөг орчин үеийн хот байгуулалтын бодлоготой уялдуулан боловсруулж хэрэгжүүлэх, түүнд шаардагдах хөрөнгийг жил бүрийн орон нутгийн төсөвт тусгахаас гадна бусад эх үүсвэрээс шийдвэрлэх;
- Ерөнхий төлөвлөгөөнд тулгуурласан хэсэгчилсэн төлөвлөгөөний дагуу инженерийн дэд бүтцийг сайжруулах;
- Аймгийн төв болон сумдыг дулаан, цэвэр ус, ариутгах татуургын нэгдсэн системтэй болгох;
- Газар, түүний нөөцийн үнэлгээг нарийвчлан тогтоож, газрын харилцааны шинэтгэлийг гүнзгийрүүлэх;
- Барилгын материалын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний нэр төрөл, хэмжээг нэмэгдүүлэх, өөрийн хэрэгцээгээ хангаж, дотоод, гадаадын зах зээлд нийлүүлэх;
- Иргэд хувьдаа тохилог орон сууц барихыг дэмжиж, орон сууцжуулахдаа Налайх-Чойрын авто замын дагуу иргэдэд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар өмчлүүлэн, инженерийн дэд бүтцийн асуудлыг хамтад нь шийдвэрлэн, хотхон үүсгэх;
- Аймгийн төвийн гэр хорооллууд руу инженерийн шугам сүлжээ татаж, айл өрхүүдийг төвлөрсөн системд холбох нөхцөлийг бүрдүүлэх;
- Хувийн орон сууц барих, хямд төсөр барилгын материалаар хангах ажлыг зээлийн бодлогоор дэмжих;
- Тоногдож нурсан барилга байгууламжийн үлдэц, хаягдлыг ашиглан барилгын материал үйлдвэрлэх;
- Барилгын материалын шинжилгээний лаборатори байгуулах.
- Хонхор хотхон, сумдын төвүүдийн цэцэрлэгт хүрээлэн бүхий ногоон байгууламжийг нэмэгдүүлж, хог хаягдлын оновчтой менежмент хэрэгжүүлж, зам талбай, гэрэлтүүлэг, хаягжилтын асуудлыг цогцоор нь шийдэж, жишиг болгон тохижуулах.

Гарах үр дүн: Барилгын салбарын үйлдвэрлэлийн өсөлтийг стратегийн зорилтод заасан хэмжээнд хүргэж, хүн ам тав тухтай, аюулгүй ажиллаж амьдрах нөхцөл бололцоог хангасан, байгаль орчинд ээлтэй орчин үеийн хот байгуулалтыг хөгжүүлэх нөхцөл бүрдсэн байна.

Стратегийн зорилт 2. Хүн амын өсөлт, орон сууцны хэрэгцээтэй уялдуулан иргэдийн орон сууцны хангамжийн түвшинг дээшлүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Орон сууц хангамжийн талаар мэдээллийн сан бүрдүүлэх;
- Бага орлоготой болон залуу гэр бүлийг орон сууцаар хангах дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;
- Төрийн албан хаагчдад зориулсан орон сууцны хоёр дахь шатны төсөл хэрэгжүүлэх;
- Орон гэргүй ядуучуудыг орон байраар хангах цогц арга хэмжээ авах;
- Орон сууц барихад улсын болон хувийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх;

Гарах үр дүн: Аймаг, сумын төвийн хүн амын өсөлт, орон сууцны хэрэгцээтэй уялдан, орон сууцны хангамжийн түвшин дээшилсэн байна.

ТАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГО

Говьсүмбэр аймгийн хөгжлийн 6 дахь тэргүүлэх чиглэлийн хүрээнд дараахи стратегийн зорилтуудыг хэрэгжүүлнэ.

Үндэслэл: Говьсүмбэр аймаг байгалийн бүтцийн хувьд дов толгод бүхий хээр талын бүсэд оршдог. Нутгийн хамгийн өндөр цэг нь далайн төвшнөөс дээш 1620 метр. Уур амьсгалын хувьд хуурайдуу сэрүүвтэр. Өвлийн улиралд хамгийн хүйтэн нь -33 хэм, зуны улиралд хамгийн халуун нь +32 хэм хүртэл дулаарах хандлага тохиолддог. Жилдээ 200-250 мм хур тунадас унадаг, тал хээрийн хүрэн, хүрэн цайвар хөрстэй.

Өвөлд орох цасны дундаж хэмжээ 10 см-ээс бага, цас тогтох хугацаа 11-р сарын 21-12-р сарын 1, цас арилах хугацаа 3-р сарын 15 хүртэл үргэлжилдэг, салхины хамгийн их хурд 25 м/секунд, аймгийн нутагт хүйтэвтэр хоногийг авч үзвэл хамгийн олон нь 122 хоног, хамгийн цөөн нь 95 хоног, хүйтэрдэггүй хоног 80-100 хоног байдаг.

Аймгийн хэмжээгээр нийт 22 уурын зуух жилд 21640 тн, үүнээс 700 гаруй өрх өвлийн улиралд 4000 тн нүүрс шатааж байгаа, 800 гаруй автомашин, өөрөө явагч хэрэгслээс ялгарах утаа, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайн тоосжилт зэрэг нь агаар мандлыг бохирдуулах гол эх үүсвэр болж байна.

Авто тээврийн хэрэгсэл олширсноос олон салаа зам бий болсон, ахуйн хог хаягдал ихэссэн, ухагдаж эвдэрсэн газрыг нөхөн сэргээгээгүй зэргээс болж төв суурин газрын хөрс эвдрэлд орсон, төв суурин газар ногоон байгууламжгүй зэргээс шалтгаалан шороон шуургатай байх өдрийн тоо нэмэгдэж, элсний нүүлт ихсэн цөлжилт эрчимтэй явагдаж байна.

Нийт бэлчээр ашиглалт жигд бус, ургамлын нөмрөг удаан хадгалагддаг нутагт мал хэт олноор бөөгнөрснөөс ургамлын хэнзлэлт, нөхөн ургалт байхгүй болж бэлчээр сэргэх нөхцөлгүй болж байна.

Тус аймагт 4 баг, 11 овог, 20 төрөлд хамрагдах амьтан тархсан, 4 төрлийн туурайтан, 7 төрлийн махчин, 5 зүйл мэрэгч, 8 төрлийн жигүүртэн, хэвлээр явагч амьтан, шавьжтай, Чойрын богд, Сансар уулын орчимд 150 гаруй аргаль нүүдэллэн амьдардаг. Жигүүртэн шувуудаас талын бүргэд, элээ, харцага, сар, ууль, ховордсон шувуудаас цармын бүргэд, идлэг шонхор зэрэг шувууд уул, хад асга бүхий газар үүр засан амьдардаг.

Тус аймаг говь хээрийн бүсэд оршдог учир гадаргын усны сүлжээгүй, усны бүх хэрэглээг газрын доорх усаар хангадаг, ус нь эрдэсжил хатуулаг ихтэй, ашиглахад тэр бүр тохиромжгүй. Усан хангамжийн үйлдвэрлэлийн лабораторгүй, цэвэр усан хангамжийн шугам хоолой хуучирсан, усан дахь төмрийн агууламж хэт их байдаг зэргээс шалтгаалан чанарын баталгаатай ундны ус хэрэглэж чадахгүй байна. Гэр хороололд амьдардаг 1 хүнд хоногт дунджаар 8-9 л ус ногдож байгаа нь эрүүл ахуйн шаардлагаас даруй 4-5 дахин бага байна. Бэлчээрийн усан хангамжийн хувьд өрөмдмөл, богино яндант, энгийн, бетонон хашлагатай худаг 246 байгаагаас Сүмбэр суманд 197, Баянтал суманд 15, Шивээговь суманд 34 байгаагаас одоогоор Сүмбэр суманд 188, Баянтал суманд 8, Шивээговь суманд 28 бүгд 224 худаг ашиглагдаж байна.

Тус аймаг байнгын урсгалтай Хулгар, Уулзвар, Цоорхойн рашаан, Хүхээ, Цагаан Ус, Уст ханан, Шивээгийн булаг зэрэг 16 гол горхи булаг шандтай, уул уурхайн болон хүний буруутай үйл ажиллагаанаас болж усны төвшин буурах, булаг шанд ширгэх үзэгдэл ажиглагдаж байна.

Бүх үе шат (2010-2021 он):

Стратегийн зорилт 1 Цөлжилт, хөрсний эвдрэл үүсч байгаа, бэлчээрийн даац хэтэрсэн газарт ногоон бүс, ойн зурвас байгуулах, газрын хөрсийг нөхөн сэргээх, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах замаар байгаль орчны доройтлыг сааруулна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Аймаг, сумдын байгаль орчны мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх;
- Байгаль орчинд учирсан хохирлын эдийн засгийн үнэлгээнд тулгуурлан нөхөн сэргээх бодлогыг хэрэгжүүлэх;
- Орон нутаг, бүс нутгийн хэмжээнд агаар мандлыг хамгаалах, түүнд үзүүлж буй сөрөг нөлөөллийг багасгах, бохирдуулагч эх үүсвэрийг бууруулах чиглэлээр шинэ техник-технологийг ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахад эдийн засгийн хөшүүрэг хэрэглэх;
- Төвлөрсөн уурын зуух болон бусад объектуудад байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ хийлгэх, тодорхой хөтөлбөртэй ажиллуулах, тогтмол хяналт тавих;
- Бүх төрлийн тээврийн хэрэгслийн хорт утаа ялгаруулалтын түвшинг техник оношлогооны төвөөр тогтоолгох, айл өрхийн ердийн галлагаат зуухыг түлш бага зарцуулдаг, утаагүй зуухаар шинэчлэх ажлыг эрчимжүүлэх, сэргээгдэх эрчим хүч ашиглах хувь хэмжээг нэмэгдүүлэх;
- Төв суурин газарт ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор жил бүр албан байгууллагууд эзэмшил газартаа 10 –аас доошгүй, айл өрх бүр 5-аас доошгүй мод бут тарьж арьчлан ургуулах, нийтийн эзэмшлийн газруудыг цэцэрлэгжүүлэх, зүлэгжүүлэх, энэ ажилд ард иргэдийг оролцуулан бүх нийтийн хөдөлгөөн болгон өрнүүлэх;
- Аймгийн төв болон сумдын төв дэх хуучин барилгын туурь балгасыг бүрэн цэвэрлэх
- Элсний нүүлтийг зогсоох ногоон байгууламж бий болгох, сул элстэй газруудад элс тогтоогч ургамал тарьж ургуулах, ургамлан нөмрөг бий болгох, ойн зурвас байгуулах, энэ ажилд уул уурхайн компаниудаас санхүүгийн дэмжлэг авах
- Төв суурин газрын ойролцоох ухагдаж эвдэрсэн газар, нүх шуудууг тэгшилж, хөрсжүүлэх;
- Суурин газрын болон хөдөөгийн замын сүлжээтэй болж, тэмдэгжүүлэх;
- Хот, суурин газрын хатуу хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, ялган ангилах, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, байгальд халгүй аргаар устгах технологи, менежмент нэвтрүүлэх;

Гарах үр дүн: Байгаль орчинд нөлөөлөгч хүчин зүйлүүдийн сөрөг нөлөөлөл буурч, байгаль орчны доройтлын түвшин буурсан байна.

Стратегийн зорилт 2. Газар ашиглалтын оновчтой тогтолцоо бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Газар ашиглалтын мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, газрын нөөцийн менежментийг сайжруулах;
- Аймгийн нутаг дэвсгэрт илэрсэн ашигт малтмалуудын нөөцийг нарийвчлан тогтоож байгаль орчинд халгүй арга технологиор ашиглах, лиценз олголтыг зогсоох;

- “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь хэмжээний тухай” хуулийн дагуу Газрын төлбөр, ус рашаан ашигласны төлбөрийн 10-аас доошгүй хувийг Байгаль хамгаалах санд төвлөрүүлж газрыг нөхөн сэргээх, хамгаалах, хөрсжүүлэх, ургамалжуулах болон ногоон байгууламжийг өргөтгөх, мод бут тариалах, цөлжилтөөс сэргийлэх зэрэг үйл ажиллагаанд зарцуулах;
- Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын лиценз эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах арга хэмжээнд шаардагдах зардлын 50-иас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг аймаг, сумдын тусгай дансанд төвлөрүүлэх;
- Тариалангийн эргэлтээс хасагдаж байгаа талбайд олон наст ургамлын үр тарих, бэлчээрийн нөөцөд шилжүүлэх, тэжээлийн болон эмийн ургамал тариалах.
- Барилга хот байгуулалт, засмал замын ажилд шаардлагатай карьерийг олгож, ашиглаж дууссан карьерийн газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх.

Гарах үр дүн: Газар ашиглалт сайжирч, бэлчээрийн даац хэтрэлт, хөрсний эвдрэл багассан байна.

Стратегийн зорилт 3. Усны нөөцийг бохирдол, хомсдолоос хамгаалах, зохистой ашиглах, хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усаар хангах нөхцөл бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- “Ус” дэд хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх;
- Аймгийн усны нөөцийн мэдээллийн сан бүрдүүлэх;
- Усны гидрохимийн лабораторитой болж, ундны усны чанарын шинжилгээг тогтмолжуулах;
- Хүн амыг УСТ-900-92-н шаардлагад нийцсэн ундны усаар хангах зорилгоор эрдэсжилтийг багасгах бага оврын тоног төхөөрөмжийг сумдад түгээх, төв, суурин газрын ундны усны эх үүсвэрийг хамгаалах;
- Үйлдвэрлэлийн болон ахуйн хэрэглээний хаягдал усыг цэвэрлэх, дахин ашиглах технологийг нэвтрүүлэх;
- Төвлөрсөн усан хангамжийн системийн шугам сүлжээнд усны алдагдал гаргахгүй байх, суурин газрын усны зарцуулалтыг тоолууржуулах, гэр хорооллын усан хангамжийг сайжруулах;
- Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг хэрэгжүүлэх;
- Сүмбэр сумын төв болон төмөр замын хэсгийг аймгийн төвийн цэвэрлэх байгууламжтай холбох;
- Бэлчээрийн уст цэгүүдийг засварлах, нөөцөд авах, эзэнжүүлэх;
- Хурын усыг хуримтлуулж хөв, цөөрөм байгуулан усны нөөцийг нэмэгдүүлэх;
- Усны эх үүсвэрийг бохирдох, хомсдохоос урьдчилан сэргийлэх, гол горхи, булаг шанд, рашааны эхийг тохижуулан хамгаалах, тарималжуулах;

Гарах үр дүн: Аймгийн усны нөөцийг оновчтой ашиглах, хамгаалах нөхцөл бүрдэж, хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан усы хэрэглээ нэмэгдсэн байна.

Стратегийн зорилт 4. Биологийн төрөл зүйлийг зохистой ашиглах, ховордож цөөрч буй ургамал амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх замаар экологийн тэнцвэрт байдлыг хангана.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Аймгийн тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөх;
- Аймгийн ангийн нөөцийг тогтоолгох, биологийн төрөл зүйлийн нөөц, тархалт, нутагшилтын мэдээллийн сан бүрдүүлэх;
- Аймгийн биологийн төрөл зүйлийг хамгаалах хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх, биологийн төрөл зүйлийн төлөв байдал, нөөц, хомсдолын шалтгаан, үр дагаварыг тодорхойлон нөхөн сэргээх
- Зөвшөөрөлгүйгээр ан амьтан агнах, барих, байгалийн ургамал ашиглах зэрэгт тавих хяналтыг чангатгах, ховордсон болон устаж болзошгүй амьтан ургамлыг хамгаалахад биотехникийн арга хэрэглэх;
- Нэн ховор, устах аюул нүүрлэж буй амьтан, ургамлыг хамгаалах, нөхөн сэргээн нутагшуулах арга хэмжээ авах;

Гарах үр дүн: Аймгийн биологийн зарим төрөл зүйлийг хамгаалж, тэдний хэвийн өсөлтийг хангах суурь нөхцөл бүрдсэн байна.

Стратегийн зорилт 5. Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтэд дасан зохицох чадавхийг бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Байгалийн гамшгийн мэдээллийн болон хөрөнгийн сан бүрдүүлэх;
- Байгалийн гамшигаас урьдчилан сэргийлэх, гамшигаас хамгаалах багаж хэрэгслээр хангах, машин техникийн паркт шинэчлэлт хийх;
- Цаг уурын хэмжилтийн цэгийн нягтрал, тэдгээрийн хэмжилтийн тоо, хэмжих элементүүдийг нэмэгдүүлэх;
- Ус цаг уурын албыг агаарын бохирдлыг хэмжих багаж тоног төхөөрөмжтэй болгох, ус цаг уурын ажиглалтын цэгийг Сүмбэр сумын Малхын багт шинээр байгуулах
- Шивээговь суманд 2011 онд агаарын чанарын хяналтын харуул болон цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны тунадас хэмжих цэгийг, Баянтал суманд 2013 онд цаг уурын харуул байгуулж автомат станц байгуулах
- 2015 онд багтаан цаг уурын харуулуудад автомат станц суурилуулж, агаарын чанарын харуулд давхар хариуцуулах;

Гарах үр дүн: Байгаль, цаг уурын онц аюултай үзэгдлээс урьдчилан сэргийлэх, түүнээс тохиолдох гамшгийн хохирлыг бууруулах, шуурхай арилгах аймгийн хэмжээний оновчтой тогтолцоо бүрдсэн байна.

**ЗУРГАА. НУТГИЙН УДИРДЛАГА, ИРГЭНИЙ НИЙГМИЙН
ОРОЛЦОО, ТҮНШЛЭЛИЙГ ХАНГАХ БОДЛОГО**

Нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагын чадавхийг бэхжүүлэн төрийн үйлчилгээний өндөр соёл, хүртээмж, сэтгэл ханамжийг төлөвшүүлсэн, хүний ажиллаж, амьдрах орчин, нөхцөлийг хангасан шилдэг аймаг байх бодлого баримтална.

Бүх үе шат (2010-2021 он):

Стратегийн зорилт 1. Нутгийн хурал, захиргааны байгууллагын шийдвэр гаргах үйл явцын ил тод байдлыг хангаж, түүнд иргэд оролцох боломжийг бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшил болон төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх чиглэл баримтлах;
- Нутгийн өөрөө удирдах ёсны болон захиргааны байгууллагын удирдлагад иргэний нийгмийн оролцоог хангах үүднээс төрийн байгууллагад хяналт тавих, нөлөө үзүүлэх, дэмжлэг авах, ажил гүйцэтгэх зэрэг төр-иргэний нийгмийн бүх талын түншлэлийг хөгжүүлэх;
- Нутгийн хурал, захиргааны байгууллагын шийдвэр гаргахын өмнө иргэдийн санал, бодлыг авч тусгах бодлого барих бөгөөд аймагтаа иргэний танхим байгуулж ажиллуулна;
- “Орон нутгийн хөгжилд иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоо” хөтөлбөр хэрэгжүүлэх.

Гарах үр дүн: Нутгийн хурал, захиргааны байгууллагын шийдвэр гаргах үйл явц ил тод болж, түүнд иргэдийн санаа бодлыг тусгах боломж нөхцөл бүрдсэн байна.

Стратегийн зорилт 2. Төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулж, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн шуурхай хүргэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Багийг төрийн үйлчилгээг иргэдэд хүргэдэг төрийн захиргааны хамгийн анхан шатны нэгжийн хувьд бэхжүүлэн хөгжүүлж, багуудыг өөрийн байртай болгох;
- Нэг иргэнд суурилсан нэг бүртгэлийн тогтолцоог бий болгох;
- Төрийн бүртгэлийг цахим хэлбэрт бүрэн шилжүүлж, иргэний баримт бичгийг цахимжуулах;
- Төрийн албаны төлөвлөлтийг сайжруулж, гүйцэтгэлд үндэслэсэн удирдах, манлайлах чадавхийг бэхжүүлэх;
- Дотоод шийдвэр нь ил тод ажлын гүйцэтгэлд чиглэсэн суралцагч байгууллагыг хөгжүүлэх;
- Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийн талаарх нийгмийн аудитыг нэвтрүүлэх;
- Төрийн байгууллагуудын үйлчилгээний стандартыг бий болгон хэвшүүлэх;
- Байгууллага, иргэдээс гаргасан санал, хүсэлт, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдлыг хянах цахим нээлттэй системтэй болох;
- Төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хийгдэх хяналт-шинжилгээ, үнэлгээний чадавхи, үр нөлөөг дээшлүүлэх.

Гарах үр дүн: Сум багаас иргэдэд хүргэх төрийн үйлчилгээ хүнд сурталгүй шуурхай болсон байна. Төрийн албаны гүйцэтгэл сайжирсан байна.

Стратегийн зорилт 3. Иргэдийн амгалан тайван, аюулгүй, тавтай амьдрах орчин, нөхцөлийг хангаж, түүнд олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Аймгийн хэмжээнд хууль тогтоомж, төр, засгийн болон хурал, захиргааны бодлого, шийдвэрийг иргэдэд шуурхай хүргэх, сурталчлах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
- Улсын бүртгэлийн нэгдсэн санд суурилсан үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх;
- Иргэдийн амгалан тайван, аюулгүй ажиллаж, амьдрах орчин, нөхцөл бүрдүүлэхэд байгууллага, иргэдийн хүч анхаарлыг төвлөрүүлж, тэдний оролцоо, дэмжлэгтэйгээр гэмт хэрэг, зөрчлийг бууруулах;
- Хууль хяналтын байгууллагуудын ажиллах нөхцөл, боломжийг сайжруулах, орчин үеийн ажлын арга хэлбэрийг нэвтрүүлэх;
- Орон нутгийн хамгаалалтад тулгуурласан батлан хамгаалах бодлого баримтлан аймгийн байгууллага, аж ахуйн нэгж, хүн амыг болзошгүй гамшиг, ослоос сэргийлэх, хамгаалах чадамжийг дээшлүүлэх;
- Нутгийн олон түмэн, уугуул иргэдийн сэтгэл, ашиг сонирхол, мэдлэг, хөрөнгө, чадавхийг хөгжлийн бодлогод чиглүүлэх;
- Аж ахуй сэргээх, шинэ үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, дэд бүтэц сайжруулах, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, нөөц баялагийг үр ашигтай ашиглан амьдрал ахуйгаа дээшлүүлэх үйл хэрэгт нутгийн ард иргэдийг эн тэргүүнд оролцуулах;
- Аймгийн хөгжилд төрийн бус байгууллагын идэвхитэй оролцох бололцоо бүрдүүлэх, төрийн бус байгууллагаас хөгжлийн цогц бодлогын хэрэгжилтэд хяналт тавих механизм бий болгох;
- Бизнес эрхлэгчдийг бүх талаар дэмжих;
- Иргэд эрүүл, цэвэр орчинд аж төрж амьдрах, ажиллах, сурч боловсрох бололцоо, нөхцлийг бий болгоход төрийн бус байгууллагын үүрэг, оролцоог сайжруулах;
- Ажлын байрны эрүүл ахуйн байдал, хөдөлмөр хамгаалал, амьжиргааны зохистой арга барилд ажилчдыг сурган дадлагажуулж, мэргэшүүлэх;
- Аливаа хөгжлийн асуудлаар эрдэмтэд, мэргэжилтний зөвлөмж, саналыг авч байх, судалгаа, мэдээллийг өргөн ашиглах.

Гарах үр дүн: Иргэдийн амьдрах, ажиллахад ээлтэй, аюулгүй орчин бүрдсэн байна.

Стратегийн зорилт 4. Аймгийн гадаад харилцаа, түншлэлийг өргөжүүлэн хөгжүүлж бэхжүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Гадаад харилцааг эдийн засагжуулах бодлого баримталж, үр ашигтай, үр нөлөөтэй гадаад харилцааг өргөжүүлж, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар орон нутгаа хөгжүүлэх;
- Хөрш хоёр орны уламжлалт харилцаат муж болон бусад улс орны мужтай харилцан ашигтай гадаад харилцааг идэвхжүүлж, бүс нутаг, олон улсын байгууллагуудын үйл ажиллагаанд идэвхтэй оролцох;
- Говьсүмбэр нутгийг хөгжүүлэхийн төлөө сэтгэл, зүтгэлтэй бусад аймаг, нийслэл, гадаад, дотоодод ажиллаж, амьдарч байгаа бүх иргэд, ажил хэрэгч хүмүүс, эрдэмтэд, түншүүдтэй нягт хамтран ажиллах;

- Хил залгаа бүх аймгуудтай эдийн засаг, нийгмийн бүх хүрээнд бизнесийн бүх чиглэлээр түншлэн ажиллах.

Гарах үр дүн: Гадаад харилцаанд үр ашигтай түншлэл бий болж, орон нутгийн хөгжилд оруулах хувь нэмэр нь дээшилсэн байна..

ДОЛОО. ХҮРЭХ ГОЛ ҮР ДҮН, ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ МЕХАНИЗМ

7.1. Цогц бодлогыг хэрэгжүүлснээр хүрэх гол үр дүн

Говьсүмбэр аймгийн хөгжлийн цогц бодлогыг хэрэгжүүлснээр дараах томоохон үр дүнд хүрнэ:

I үе шат (2010-2015 он)-ны эцэст бизнесийн үйл ажиллагаа идэвхжиж, эдийн засгийн эрчимтэй өсөлтийг хангах тааламжтай нөхцөл бүрдэхийн зэрэгцээ уул уурхай, боловсруулах үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ өргөжиж, эрчимжсэн хөдөө аж ахуй болон аялал жуулчлал хөгжин аймгийн эдийн засгийн бүтцэд өөрчлөлт гарч, аж үйлдвэрийн эзлэх байр суурь сайжирна.

Өмнөх онуудад хүрсэн түвшингээ хадгалбал Говьсүмбэр аймгийн бодит ДНБ-ий хэмжээ 2010-2021 онд жилд дунджаар 15.8 хувийн өсөлттэй байх ба 2021 онд 2005 оны үнээр тооцвол 196570.5 сая төгрөгийн бараа, үйлчилгээ үйлдвэрлэх боломжтой болж 2015 онтой харьцуулбал ДНБ-ий хэмжээ 2021 онд 2.1 дахин нэмэгдэх болно.

2010-2015 онд аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн жилийн дундаж өсөлт 26.3 хувьтай байх ба тус салбарын аймгийн ДНБ-д эзлэх хувь 2009 онд 20 хувь байсан бол 2015 онд 30 хувьд хүрч экспортын баримжаатай үйлдвэрлэлийн үндэс суурийн эхлэл тавигдана.

Боловсруулах салбарын үйлдвэрлэл энэ үе шатанд жилд дунджаар 12 хувиар өсч, аж үйлдвэрийн салбарт эзлэх хувийн жин нэмэгдэнэ.

Уул уурхайн салбарын үйлдвэрлэл энэ үе шатанд жилд дунджаар 42.1 хувиар өсч, аж үйлдвэрийн салбарт уул уурхайн салбарын эзлэх хувийн жин 88 хувьд хүрнэ.

Эрчим хүчний салбарын үйлдвэрлэл энэ үе шатанд жилд дунджаар 1.5 хувиар өсч, тус салбарын аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлд эзлэх хувийн жин 2015 онд 20 хувьд хүрнэ.

Барилгын салбарын үйлдвэрлэлийн жилийн дундаж өсөлтийг 2015 онд 12 хувьд хүргэнэ.

Бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлснээр малын үүлдэрлэг чанар сайжирч, хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл энэ үе шатанд жилд дунджаар 7.6 хувиар өсч, ХАА-н салбарын үйлдвэрлэлийн ДНБ-д эзлэх хувь 2015 онд 7.9 хувь болж өөрчлөгдөнө.

Үйлчилгээний салбарын үйлдвэрлэл энэ үе шатанд жилд дунджаар 12.8 хувиар өсч, тус салбарын ДНБ-д эзлэх хувийн жин 35.2 хувьд хүрч аймгийн эдийн засгийн бүтцэд нилээд өөрчлөлт орно.

Аймгийн хөгжлийн цогц бодлогын эхний үе шат хэрэгжсэнээр нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 2009 онд 2.6 сая төгрөг байсан бол 2015 онд 6.7 сая төгрөгт хүрч, нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 2009 онтой харьцуулбал 2.6 дахин нэмэгдэх эцсийн үр дүнд хүрнэ.

Эдийн засгийн эдгээр өсөлтийн үр дүнд ажлын байр олноор бий болж, ажилгүйдэл, ядуурлын түвшин буурч, хүн амын орлого нэмэгдэж, амьжиргааны түвшин дээшилсэн байна.

ЕБС-ийг 12 жилийн тогтолцоонд бүрэн шилжүүлж, хамран сургалтын бохир жин мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлогод дэвшүүлсэн зорилтыг бүрэн хангасан байна.

Сум, аймгийн эмнэлгийн 60 хувийг эмчилгээ, оношлогооны тоног төхөөрөмжөөр хангаж, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, чанарын түвшинг 75 хувьд хүргэнэ.

II үе шат (2016-2021 он)-ны эцэст аймгийн эдийн засгийн бүтэц ихээхэн сайжирч, дэвшилтэт техник, технологи, менежмент бүхий үйлдвэрлэл, үйлчилгээ өссөнөөр мэдлэгт суурилсан эдийн засгийн үндэс суурь тавигдах ба өмнөх үе шатанд байгуулагдсан уул уурхайн болон боловсруулах салбарын үйлдвэрүүдийн үйл ажиллагаа жигдрэнэ.

Нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 2009 онд 2.6 сая төгрөг байсан бол 2021 онд 13.6 сая төгрөгт хүрч 2009 онтой харьцуулбал нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 5.2 дахин нэмэгдсэн байх болно.

2016-2021 онд аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн жилийн дундаж өсөлт 17.5 хувь байх ба аймгийн ДНБ-д эзлэх хувийн жин 2021 онд 34.4 хувьд хүрнэ.

Боловсруулах салбарын үйлдвэрлэл энэ үе шатанд жилд дунджаар 6.9 хувиар өснө.

Харин олборлох салбарын үйлдвэрлэл энэ үе шатанд жилд дунджаар 19.3 хувиар өсч, аж үйлдвэрийн салбарт уг салбарын эзлэх хувийн жин 95 хувьд хүрэх болно.

Эрчим хүчний салбарын үйлдвэрлэл энэ үе шатанд жилд дунджаар 1.4 хувиар өсч, аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлд эрчим хүчний салбарын үйлдвэрлэлийн эзлэх хувийн жин 2021 онд 7.1 хувь болно.

Барилгын салбарын үйлдвэрлэлийн жилийн дундаж өсөлт энэ үе шатанд 7 хувь байх ба уг салбарын аймгийн ДНБ-д эзлэх хувийн жинг нэмэгдүүлнэ.

ХАА-н салбарын үйлдвэрлэл энэ үе шатанд жилд дунджаар 5.1 хувиар өсч, 2021 онд ХАА-н салбарын ДНБ-д эзлэх хувь 5.1 хувь болж өөрчлөгдөнө.

Үйлчилгээний салбарын үйлдвэрлэл энэ үе шатанд жилд дунджаар 7.2 хувиар өсөх ба үйлчилгээний салбарын ДНБ-д эзлэх жин 2021 онд 25.4 хувь болно. Харин үйлчилгээний салбарт худалдааны салбарын эзлэх хувийн жин 35.4 хувьд, санхүүгийн салбарын эзлэх хувийн жин 36.8 хувьд тус тус хүрэх болно.

Аймгийн цогц бодлогын хоёрдугаар үе шат хэрэгжсэнээр нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 2021 онд 13.6 сая төгрөгт хүрэх эцсийн үр дүн ажиглагдаж байна.

Аймгийн нийт хүн амын дотор дундаж орлоготой иргэдийн эзлэх хувийн жин 60 хувьд хүрсэн байна.

Бүх шатны сургуулийн хамран сургалт 100 хувьд хүрнэ.

Сум, аймгийн эмнэлгүүдийн хэрэгцээ бүрэн хангагдаж, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, чанарын түвшинг 95 хувьд хүрнэ.

Нийгмийн халамжийн үйлчилгээний хамрах хүрээ оновчтой болж, үр ашиг нь дээшилсэн байна.

7.2. Цогц бодлогын хэрэгжилтийг хангах механизм

Говьсүмбэр аймгийн хөгжлийн цогц бодлогыг аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэр, аймгийн нийгэм, эдийн засгийн жил бүрийн төлөвлөгөө болон энэ баримт бичгийн хүрээнд боловруулах дэд хөтөлбөр, мастер төлөвлөгөө, төслүүдэд тусган хэрэгжүүлнэ.

Говьсүмбэр аймгийн хөгжлийн цогц бодлогод тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны явцад тухай бүр хяналт, шинжилгээ хийж, ахиц дэвшил, үйл ажиллагааны үр дагаврыг үнэлэн дүгнэх ажлыг дараах байдлаар зохион байгуулна:

Говьсүмбэр аймгийн хөгжлийн цогц бодлогын жил бүрийн хэрэгжилтийн явцад хяналт, шинжилгээ, үнэлгээ хийсний үндсэн дээр Засаг дарга дараа жилийн эхний улиралд багтаан Иргэдийн төлөөлөгчдийн хуралд тайлагнана.

Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтын хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ хийх, үр дүнг үнэлэн дүгнэх үе шатууд:

I үе шат: Бодлогын зорилтын дунд шатны үнэлгээ хийх (Хугацаа: 2015 оны 6 дугаар сарын 30-ны өдөр);

II үе шат: Бодлогын зорилтын эцсийн шатны үнэлгээ хийх (Хугацаа: 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдөр).

Хяналт, шинжилгээ, үнэлгээг аймгийн төрийн захиргааны төв байгууллага холбогдох мэргэжлийн болон судалгааны, түүнчлэн төрийн бус байгууллагуудын оролцоотойгоор нэгдсэн төлөвлөгөөний үндсэн дээр хийх бөгөөд зохих зардлыг жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлнэ. Хяналт, шинжилгээ тасралтгүй явагдана.

Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт бүрийн хэрэгжилтийн үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлтийг тухай бүр үнэлгээ хийхийн өмнө урьдчилан тодорхойлж боловсруулсан байх бөгөөд гол анхаарал хандуулах зарим зорилтын үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлтийг салбар тус бүрээр урьдчилан тодорхойлж байх болно.

Хавсралт 1

“Говьсүмбэр аймгийн хөгжлийн цогц бодлого” (2010-2021)-ын тооцооны үндэслэл

Говьсүмбэр аймгийн 2010-2021 он хүртэлх хөгжлийн цогц бодлогыг тоон мэдээллээр хангахын тулд Говьсүмбэр аймгийн Статистикийн хэлтсээс гаргасан Статистикийн эмхэтгэл, ҮСХ-оос гаргадаг Статистикийн эмхэтгэл зэргийг ашиглав.

Тооцооны үндэслэлийг гаргахдаа тус аймгийн 2005-2009 оны үзүүлэлтүүдэд тулгуурласан бөгөөд бүх үзүүлэлтүүдийг 2005 оны үнээр тооцсон болно. Харин хэрэглээний үнийн индексийг улсын хэмжээнд гаргадаг үзүүлэлтээр авч үзэв.

Говьсүмбэр аймгийн бодит ДНБ-ий хэмжээ 2010-2021 онд жилд дунджаар 15.8 хувийн өсөлттэй байх ба 2021 онд 2005 оны үнээр тооцвол 196570.5 сая төгрөгийн бараа, үйлчилгээ үйлдвэрлэх боломжтой бөгөөд 2015 онтой харьцуулбал ДНБ-ий хэмжээ 2021 онд 2.1 дахин нэмэгдсэн байх хандлагатай байна.

Нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 2009 онд 2.6 сая төгрөг байсан бол 2021 онд 13.6 сая төгрөгт хүрч 2009 онтой харьцуулбал нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 5.2 дахин нэмэгдсэн байх болно.

Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн талаар

Нэгдүгээр үе шат: (2010-2015 он): Аж үйлдвэрийн салбарын ДНБ-д эзлэх хувь 2009 онд 20 % байсан бол 2015 онд 30 %-д хүрэх болно. Аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн жилийн дундаж өсөлт 26.3 % байх үр дүн ажиглагдаж байна.

Хоёрдугаар үе шат: (2016-2021 он): Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн жилийн дундаж өсөлт хоёрдугаар үед 17.5 % байх ба ДНБ-д эзлэх хувийн жинг 2021 онд 34.4 хувьд хүргэнэ.

Боловсруулах салбарын үйлдвэрлэлийн талаар

Нэгдүгээр үе шат: (2010-2015 он): Боловсруулах салбарын үйлдвэрлэлийг энэ үе шатанд жилд дунджаар 12 хувиар өсгөж, аж үйлдвэрийн салбарт эзлэх хувийн жинг нэмэгдүүлэх үндэс суурийн эхлэлийг бий болгож чадна.

Хоёрдугаар үе шат: (2016-2021 он): Боловсруулах салбарын үйлдвэрлэл энэ үе шатанд жилд дунджаар 6.9 хувиар өснө.

Уул уурхай буюу олборлох салбарын үйлдвэрлэлийн талаар

Нэгдүгээр үе шат: (2010-2015 он): Уул уурхайн салбарын үйлдвэрлэлийг энэ үе шатанд жилд дунджаар 42.1 хувиар өсгөнө. Аж үйлдвэрийн салбарт уул уурхайн салбарын эзлэх хувийн жинг 88 %-д хүргэнэ.

Хоёрдугаар үе шат: (2016-2021 он): Олборлох салбарын үйлдвэрлэлийг энэ үе шатанд жилд дунджаар 19.3 хувиар өсгөнө. Аж үйлдвэрийн салбарт уг салбарын эзлэх хувийн жин 95 %-д хүрэх болно.

Эрчим хүчний салбарын үйлдвэрлэлийн талаар

Нэгдүгээр үе шат: (2010-2015 он): Эрчим хүчний салбарын үйлдвэрлэлийг энэ үе шатанд жилд дунджаар 1.5 хувиар өсгөнө. Уг салбарын аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлд эзлэх хувийг 2015 онд 20 хувьд хүргэнэ.

Хоёрдугаар үе шат: (2016-2021 он): Эрчим хүчний салбарын үйлдвэрлэл энэ үе шатанд жилд дунджаар 1.4 хувиар өснө. Аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлд эрчим хүчний салбарын үйлдвэрлэлийн эзлэх хувийн жин 2021 онд 7.1 хувь болно.

Барилгын салбарын үйлдвэрлэлийн талаар

Нэгдүгээр үе шат: (2010-2015 он): Барилгын салбарын үйлдвэрлэлийн жилийн дундаж өсөлтийг 2015 онд 12 хувьд хүргэнэ.

Хоёрдугаар үе шат: (2016-2021 он): Барилгын салбарын үйлдвэрлэлийн жилийн дундаж өсөлт энэ үе шатанд 7 хувь байх ба уг салбарын аймгийн ДНБ-д эзлэх хувийн жинг нэмэгдүүлнэ.

ХАА-н салбарын үйлдвэрлэлийн талаар

Нэгдүгээр үе шат: (2010-2015 он): ХАА-н салбарын үйлдвэрлэлийг энэ үе шатанд жилд дунджаар 7.6 хувиар өсгөнө. ХАА-н салбарын үйлдвэрлэлийн ДНБ-д эзлэх хувь 2010 онд 12.7 хувь байсан бол 2015 онд 7.9 хувь болж өөрчлөгдөнө.

Хоёрдугаар үе шат: (2016-2021 он): ХАА-н салбарын үйлдвэрлэлийг энэ үе шатанд жилд дунджаар 5.1 хувиар өсгөнө. 2021 онд ХАА-н салбарын ДНБ-д эзлэх хувь 5.1 хувьд хүргэнэ.

Үйлчилгээний салбарын үйлдвэрлэлийн талаар

Нэгдүгээр үе шат: (2010-2015 он): Үйлчилгээний салбарын үйлдвэрлэлийг энэ үе шатанд жилд дунджаар 12.8 хувиар өсгөнө. Уг салбарын ДНБ-д эзлэх хувийг 35.2 %-д хүргэж салбарын бүтцэд нилээд өөрчлөлт гарах болно.

Хоёрдугаар үе шат: (2016-2021 он): Үйлчилгээний салбарын үйлдвэрлэлийг энэ үе шатанд жилд дунджаар 7.2 хувиар өсгөнө. Үйлчилгээний салбарын ДНБ-д эзлэх жин 2021 онд 25.4 хувь болно. Үйлчилгээний салбарт худалдааны салбарын эзлэх хувийн жинг 35.4 хувьд, санхүүгийн салбарын эзлэх хувийн жинг 36.8 хувьд тус тус хүргэх болно.

Нэг хүнд ногдох ДНБ

Нэгдүгээр үе шат: (2010-2015 он): Нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 2009 онд 2.6 сая төгрөг байсан бол 2015 онд 6.7 сая төгрөгт хүрч нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээг 2009 онтой харьцуулбал 2.6 дахин нэмэгдүүлнэ.

Хоёрдугаар үе шат: (2016-2021 он): Нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээг 2021 онд 13.6 сая төгрөгт хүргэнэ.

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

д/д	Он	ХАА	Олбор- лох	Боловс- руулах	Эрчим хүч	Барилга	Худал- даа	Тээвэр
1	2005	3192667.8	2357900.5	1425.6	3174446.8	0	1421589	787859

2	2006	3192000.9	945963.4	-475.8	3602919.9	0	1275287	100135
3	2007	4218678.3	1212831.4	593.8	363228.7	0	1281394	165905
4	2008	4488983.0	2093452.1	5243.6	1395630.7	10711.0	3648593	116283
5	2009	4682034.6	2523498.8	770.7	1775630.7	28840.5	5299590	61448.6

Үргэлжлэл

д/д	Он	Санхүү	Үл хөдлөх	Төр	Боловсрол	Эрүүл мэнд	Нийгмийн хамгаалал	ДНБ, мянган төгрөг
1	2005	399971	11587	434230.4	331217.0	191660	152633.2	12457187
2	2006	588503	17521	612915.3	436687.2	252078	210458.8	11233992
3	2007	897841	25664	1023557.0	821605.8	409076	181349.5	10601724
4	2008	789686	51633	1678684.0	1121881.0	550782	717068.8	16668632
5	2009	827099	70328	1537505.0	1284939.5	234355	403423.6	18729464

Эх сурвалж: Аймгийн статистикийн хэлтэс

Аймгийн ДНБ болон бусад салбарын үзүүлэлтүүдийн тооцоолол, сая төгрөг

он	ХАА	Аж үйлдвэр	Олборлох	Боловсруулах	Эрчим хүч	Барилга	Худалдаа	Тээвэр
2010	5237.6	8574.5	4419.2	8.9	4146.4	28.4	6531.1	765.3
2011	5665.2	10937.6	6715.9	10.2	4211.5	35.3	7544.0	780.0
2012	6092.7	13914.7	9626.6	11.5	4276.6	42.1	8556.9	794.7
2013	6520.3	17505.7	13151.3	12.7	4341.7	48.9	9569.9	809.3
2014	6947.9	21710.7	17289.9	14.0	4406.8	55.8	10582.8	824.0
2015	7375.4	26529.6	22042.4	15.2	4472.0	62.6	11595.7	838.7
2016	7803.0	31962.5	27409.0	16.5	4537.1	69.5	12608.7	853.3
2017	8230.6	38009.4	33389.5	17.7	4602.2	76.3	13621.6	868.0
2018	8658.2	44670.2	39983.9	19.0	4667.3	83.1	14634.5	882.7
2019	9085.7	51945.0	47192.3	20.2	4732.4	90.0	15647.5	897.3
2020	9513.3	59833.7	55014.7	21.5	4797.5	96.8	16660.4	912.0
2021	9940.9	68336.4	63451.0	22.7	4862.7	103.7	17673.3	926.7

Үргэлжлэл

он	Санхүү	Үл хөдлөх	Төр	Боловсрол	Эрүүл мэнд	Нийгмийн хамгаалал	GRDP, сая төгрөг	ДНБ-ий өсөлт, хувиа	Хүн ам
----	--------	-----------	-----	-----------	------------	--------------------	------------------	---------------------	--------

								р	
2010	6717.3	80.8	2039.1	1577.1	442.8	635.4	41204.0	19.6	13331.1
2011	7772.8	96.0	2366.3	1836.3	481.2	736.3	49188.6	19.4	13432.8
2012	8828.3	111.1	2693.5	2095.6	519.6	837.1	58401.1	18.7	13534.5
2013	9883.9	126.3	3020.8	2354.8	558.0	937.9	68841.6	17.9	13636.2
2014	10939.4	141.5	3348.0	2614.1	596.5	1038.7	80510.0	16.9	13737.9
2015	11995.0	156.6	3675.2	2873.4	634.9	1139.5	93406.3	16.0	13839.6
2016	13050.5	171.8	4002.5	3132.6	673.3	1240.4	107530.5	15.1	13941.3
2017	14106.1	186.9	4329.7	3391.9	711.7	1341.2	122882.7	14.3	14043
2018	15161.6	202.1	4656.9	3651.2	750.1	1442.0	139462.8	13.5	14144.7
2019	16217.1	217.3	4984.2	3910.4	788.5	1542.8	157270.7	12.8	14246.4
2020	17272.7	232.4	5311.4	4169.7	826.9	1643.6	176306.7	12.1	14348.1
2021	18328.2	247.6	5638.6	4429.0	865.3	1744.5	196570.5	11.5	14449.8